

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Ерөнхий зүйл:

“Монгол Улсад ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд хөдөлмөр эрхлэх чадвар, боломжийг нэмэгдүүлэх одоо хэрэгжиж буй хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хөтөлбөрүүд; инновац, санаагаа үйл хэрэг болгох экосистем; үр чадвар, чадавх хөгжүүлэх үйлчилгээ; цар хүрээг нь өргөжүүлж бодлогын чиглэл тогтооход ашиглах гэсэн тодорхой зорилтууд тавигдсан. Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгож буй өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлон судлах хэрэгцээ үүссэн болно.

Ажил мэргэжлийн чиг баримжаа /АМЧБ/ гэдэг нь хувь хүний амьдралын түршид хийж гүйцэтгэсэн ажил мэргэжил болон суралцахуйг илэрхийлсэн нэр томьёо юм. Өнгөц харахад энэ нь энгийн, хүн бүр мэдэх юм шиг хэдий ч үнэн хэрэгтээ нарийн төвөгтэй ойлголт байсаар иржээ. 1977 онд ажил мэргэжлийн боловсрол судлаач Ватц *“ажил мэргэжил нь хүний албан болон албан бус боловсролын зарчмаар сурсан сургалт бас цалинтай, цалингүй хийсэн бүх ажлын насан туршийн хөгжил дэвшил юм”* гэж тодорхойлсон байдаг.

“Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” суралцахуй гэдэг нь “суралцагчдын хөгжлийн тодорхой үе шат бүрд тохирсон мэдлэг, чадвар, хандлагыг сургалтын хөтөлбөрт тусган, ажил мэргэжилтэй холбоотой ухаалаг шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл цуглуулах, боловсруулах, үйл хэрэг болгон хөгжүүлдэг” үйл явц юм. Ажил мэргэжлийн чиг баримжааг тодорхойлох нарийн төвөгтэй үзэгдэл, үйл явцыг тодорхойлсон эрдэмтэн судлаачдын баталсан Зан төлөвийн хүчин зүйлийн онол, Хөгжлийн онол, Нийгэм танин мэдэхүйн онол, Системийн онол, Каосын онол гэсэн үзэл баримтлалууд өнөөг хүртэл хөгжиж иржээ. Эдгээр онолуудын нотолсноор ажил мэргэжлийн чиг баримжаа эзэмших үйл явц өөрийн гэсэн хөгжлийн үе шаттай байдаг ажээ.

Гинсберг (1951), Доналд Супер (1990) нарын дэвшүүлсэн Хөгжлийн онол нь ажил мэргэжлийн чиг баримжаа төлөвших үйл явцыг хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн үе шаттай холбон тодорхойлсон. Энэ онолд ажил мэргэжлийн чиг баримжааны үе шатууд нь суралцагчдын бага, дунд, ахлах сургууль болон сургууль төгссөний дараах насны онцлогоос хамаардаг учир тухайн үе тус бүрд тохирсон суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зөвлөсөн байдаг.

Хөгжлийн онолоор ажил мэргэжлийн чиг баримжаа төлөвшлийг “11 орчим насны хүүхэд тоглодог тоглоом, дуртай зүйлээрээ дамжуулан мөрөөдлийн, 13 орчим насны хүүхэд өөрийн чадвар, давуу талаа мэдэрсэн, 15-16 насны хүүхэд өөрийн зорилго, үнэт зүйлийг

илүүд үзсэн, 17-18 насандаа ирээдүйн төлөвлөлтийг харгалзахыг хичээсэн” үе хэмээн тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл хүүхдийн сэтгэлгээ, танин мэдэхүйн хөгжлийн үе шаттай ажил мэргэжлийн чиг баримжаа эзэмших хөгжлийн үе шат маш нягт уялдах учиртай ажээ. Уялдуулан хөгжүүлээгүй тохиолдолд тодорхой нэг үе шатанд “гацах” хандлага их байдаг байна. Тиймээс суралцагчдыг танин мэдэхүйн хөгжлийн үе шатны дагуу суралцах үйл явцад чиглүүлэх нь тэднийг ажил мэргэжлээ илүү бодит, ухаалаг сонголт хийх чадварт дадлагажуулдаг. Хүүхэд залуусын хувьд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, өөрийн хүсэл сонирхол, үр чадварт тохирсон чанартай мэргэжлийг эзэмшиж, ажил хөдөлмөр эрхлэх нь насан туршийн амьдралын баталгааны нэг хэсэг болох юм. Нөгөө талаасаа тэд нарт мэргэжил сонголтгоо зөв хийхэд шаардагдах мэдлэг, үр чадвар, дадлыг суулгах, ирээдүйн ажил, мэргэжлийн хүрээнд нийгэмд эзлэх өөрийн байр суурийг тодорхой болгох, карьерын хөгжлөө төлөвлөхөд туслах, дэмжих, чиглүүлэх ажлыг тасралтгүй хийж байх хэрэгтэй болдог. Тиймээс тэднийг ирээдүйн ажил, мэргэжилд нь чиглүүлж бэлтгэх нь улс орон бүрийн боловсролын болон хөдөлмөрийн салбарын хөгжил, шинэчлэлд чухал байр суурь эзэлдэг.

Монголын нөхцөлд ЕБС-ын хувьд ажил мэргэжлийн чиг баримжаа (career guidance), харин МСҮТ, ПК-ийн хувьд карьер хөгжлийн төлөвлөгөө (career development plan) гэдэг нэр томъёог хэрэглэх нь илүү тохиромжтой юм. Учир нь ажил мэргэжлийн чиг баримжаа нь ЕБС-ын суралцагч бүрт чиглэсэн, тэднийг ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, ажил мэргэжлээ сонгоход хэрэгтэй мэдээлэл өгөх, ажил мэргэжлийн сонголт хийх, түүнийхээ дагуу суралцах үйл ажиллагаагаа төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх ба карьер хөгжлийн төлөвлөгөө нь МСҮТ, ПК-ийн нэгэнт мэргэжлээ сонгоод ороод ирсэн суралцагч бүрт чиглэн хувь хүний хөгжил, сонгосон мэргэжлийн хүрээнд өөрийн карьер хөгжлийг төлөвлөх, ажлын байранд бэлдэх зэрэгт үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэнэ.

I. Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаанд их, дээд сургууль, МБСБ, ЕБС болон ажил, хөдөлмөр эрхлээгүй залуучуудад зориулсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний чиглэлээр хийгдсэн ажил, боловсруулсан гарын авлага, бүтээлүүд, онлайн үйлчилгээний талаарх баримт бичгүүдийг хамруулан судалсан.

II. Судалгааны зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь ерөнхий боловсролын сургууль болон их, дээд сургууль, ажил хөдөлмөрийн залгамж холбоог хангах үндсэн механизм болох ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажил ямар төвшинд байгааг судлан тогтоох, энэ чиглэлийн ажлын уялдааг хангах нэгдсэн цахим үйлчилгээг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгөхөд оршино.

III. Судалгааны арга зүй

Уг судалгаанд баримт материал судлах, энэ чиглэлээр судлаачдын өмнө хийсэн судалгааны материалуудад харьцуулсан шинжилгээ хийх аргыг хэрэглэв. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбогдох судалгааны эх сурвалжуудад дүн шинжилгээ хийж энэхүү асуудал өнөөгийн нөхцөл байдал ямар төвшинд байгааг тодруулан гаргасан.

IV. Судалгааны үр дүн

1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын зохион байгуулалт

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт нэгдсэн зохион байгуулалтгүй байна гэсэн дүгнэлтийг өмнөх олон төрлийн судалгаануудад дурдсан байна.

2. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг хариуцах субъектүүд

Мэргэжлийн чиг баримжаа олгох ажлын голлох субъектүүд нь хэн болох, тэдгээрийн үүрэг оролцоог тодруулж үзвэл дараах дүр зураг харагдаж байна.

ЕБС-ийн сурагчдын дунд хийсэн судалгаанаас харахад “Мэргэжлээ сонгох, энэ талын мэдээлэл олж авахад чамд хамгийн ойрын туслагч нь хэн байсан бэ?” гэсэн асуултад ахлах ангийн сурагчдын 66% нь эцэг эх, 43,4% нь ах эгч, 35,4% нь найз нөхөд гэж хариулсан. Харин тэдний 22,0% нь анги удирдсан багшаа, 10,3% нь хичээл заадаг мэргэжлийн багш нараа, 2,6% нь нийгмийн ажилтнаа ажил мэргэжлийн талаар зөвлөн туслагч гэж үзжээ.

МБСБ, их дээд сургуулийн оюутнуудын “Мэргэжлээ сонгохдоо хэнтэй хамгийн их зөвлөсөн бэ?” гэсэн хариултын давтамжийг авч үзвэл мөн л эцэг эх, гэр бүл зонхилж, найз нөхөд тодорхой байр суурь эзэлж байна. Суралцагчдын 66% нь ажил мэргэжлийн чиг баримжааны мэдээллийг эцэг эх, ах дүү найз нөхдөөсөө авдаг гэж хариулсан.

Багш, сурагч, эцэг эх, удирдлагууд элсэлтийн ерөнхий шалгалтын хичээл яаж сонгох, ямар шалгалт өгөх, шалгалтын тест дээр хэрхэн ажиллах талаар зөвлөгөө, лекц сургалтыг “ажил мэргэжлийн чиг баримжаа” олгох үйл ажиллагаа гэж ташаа ойлгож байна.

Интернэтийг өөрийн зөвлөн туслагч гэж үзэх ахлах ангийн сурагчид 11,5%-ийг эзэлж, хэнтэй ч зөвлөлгүй, өөрөө бие дааж шийдсэн гэсэн их, дээд сургуулийн оюутны хариултын давтамж багагүй байгаа нь анхаарч үзүүштэй баримт юм. Үүнээс харахад мэргэжил сонгоход хамгийн их нөлөөлөл гэр бүлийн хүрээнд байна гэсэн дүгнэлт хийж болох юм.

3. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний төрөл, агуулга

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зааснаар Хөдөлмөрийн төв бирж, аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сүм, хороонд хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /алба/ ажиллаж, хөдөлмөр эрхлэлтийн дараах нийтлэг үйлчилгээг буюу АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах ажлыг үнэ төлбөргүй олгох үүрэг хүлээдэг. Ажил мэргэжлийн чиг баримжааны талаар явуулж буй ажил үйлчилгээний хүртээмж ямар байгаа талаар нэгдсэн мэдээлэл, судалгаа хангалттай бүс байна.

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын төрөөс иргэнийхээ сурч боловсрох, мэргэжил эзэмших, мэргэжил дээшлүүлэх, хувь болон бие хүний хөгжлийг дэмжих, ажил мэргэжлээ сонгох, хөдөлмөрлөх эрх үүргийг нь тодорхой хууль, тогтоомжоор зохицуулж эхэлж байна.

“Бага, дунд боловсролын тухай” хуулийн “Бүрэн дунд боловсролын агуулга”-гэсэн бүлэгт “Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх” зорилтыг хэрэгжүүлнэ гэж заасан байдаг нь эрх зүйн хамгийн гол зохицуулалт юм.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлийн 7.1-д Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараахь чиглэлээр зохион байгуулна: 7.1.1.хувь хүний хөгжил; 7.1.2.боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан; 7.1.3.эрүүл мэнд; 7.1.4.хөдөлмөр эрхлэлт; 7.1.5.аюулгүй амьдрах, хөгжих орчин, 8 дугаар зүйлийн Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжих заалтын 8.1.1- д ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан түршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах; 8.1.2.залуучуудад зориулан хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт зохион байгуулахыг дэмжих гэж тус тус заажээ.

“Бага, дунд боловсролын тухай” хуульд ерөнхий боловсролын сургуулиудыг ердийн, мэргэжлийн, гүнзгийрүүлсэн, төрөлжсөн сургалттай гэж ангилан чиг үүргийг тодорхойлж өгсөн байдаг. Харин ахлах ангийн бүх сурагчдад зориулсан мэргэжлийн чиг баримжаа олгох томоохон үйлчилгээг сургууль дээр хэн хариуцан зохион байгуулах нь тодорхойгүй, эрх зүйн зохицуулалт, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй байна. Боловсролын салбарын санхүүжилтэд мэргэжлийн чиг баримжаа олгоход зориулж тухайлсан зардал төсөвлөдөггүй ажээ. 2009-2011 онд Боловсролын хүрээлэнгээс “ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн баримжаа олгох асуудал” сэдэвт төсөл хэрэгжүүлж, энэ төслийн хүрээнд ахлах ангид мэргэжлийн чиг баримжаа олгох гүнзгийрүүлсэн сургалтуудын үлгэрчилсэн агуулга

(хөтөлбөр), арга зүй боловсруулж туршихад бэлэн болгоод байна. Түүнчлэн сурагчдыг ажил мэргэжилд бэлтгэх, тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр суралцагч, багш, эцэг эх, олон нийтэд зориулсан зөвлөмж боловсруулжээ.

2011 оны 11-р сарын 16-ны Засгийн газрын хуралдаанаас ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгын залгамж холбоог хангаж, мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрт суралцагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрийн сахилга, хариуцлага, харилцааны соёл төлөвшүүлэх, ачаалал даах, эрсдэлийг давах чадвартай, амьдрах ухаанд сургахад чиглэсэн агуулга, хөтөлбөр боловсруулах даалгавар өгсөн байна.

АМЧБО зөвлөх үйлчилгээний талаарх төрийн тогтолцоо, эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай бөгөөд энэхүү үйлчилгээг үндэсний түвшинд хэрэгжүүлэх бодлогын зохицуулалтын чиглэлээр хамаарах хууль тогтоомжийг дурдвал:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэрт:

6.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

6.1.1. хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ;

6.1.2. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ.

6.2. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

6.2.1. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

6.2.2. ажилд зуучлах;

6.2.4. нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;

6.2.5. бусад үйлчилгээ.

6.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ:

6.3.1. хөдөлмөрт бэлтгэх;

6.3.2. хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;

6.3.6. ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

Мөн хуулийн 8 дугаар зүйлийн Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ хэсэгт:

8.1. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ хамаарна.

8.2. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчлан болон хэсэг, бүлгээр зохион байгуулна.

8.3. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг тухайн сургуулийн захиргаатай хамтран тусгайлсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

8.4. Хөдөлмөрийн бирж ажил, мэргэжлийн чиг баримжаа олгоход ашиглах гарын авлага, түгээмэл мэргэжил бүрээр танилцуулга бэлтгэж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

8.5. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын агуулга, сургагч багшид тавих шаардлагыг хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд тогтооно гэж тус тус заажээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 27.1 дэх заалтын хүрээнд Хөдөлмөрийн төв бирж, аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хороонд хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /алба/ ажиллаж, хөдөлмөр эрхлэлтийн дараах нийтлэг үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг. Үүнд: - АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах - Ажилд зуучлах - Ажилгүйдлийн тэтгэмж олгох - Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах гэж заажээ.

Мөн "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ"-нд тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил, мэргэжлээ сонгох чиглэлээр зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээг бусад үйлчилгээ хэсэгт хамаарна гэж заасан байна. Уг үйлчилгээг ганцаарчлан болон хэсэг, бүлгээр зохион байгуулах ба Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад тухайн сургуулийн захиргаатай хамтран тусгайлсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулах тухай хуульчилсан байна.

Хуулийн хүрээнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгоход ашиглах гарын авлага, түгээмэл мэргэжил бүрээр танилцуулга бэлтгэж, мэдээллийн сан бүрдүүлэх үүргийг Хөдөлмөрийн төв бирж гүйцэтгэж байна. Хөдөлмөрийн төв бирж, аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржээр дамжуулан: - Зөвлөгөө, мэдээлэл өгөх - Мэргэжил сонгох үр чадвар, хувь хүний зан төлөвийн тест, мэргэжлийн чиг хандлагыг тодорхойлох тест бөглүүлж, түүнд үндэслэн дүгнэлт хийх ба зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг хийдэг. Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэст ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох хөдөлмөр

зуучлалын мэргэжилтэн, Хөдөлмөрийн төв биржийн бүтцэд ажил, мэргэжлийн чиг баримжааны хөгжлийн алба ажилладаг юм байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 12 дугаарын 16-ны өдрийн 9 дүгээр тогтоолын долоодугаар хавсралтаар Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөрийг баталсан байна. Хөтөлбөрийн зорилго нь Хүүхэд, залуучууд, ажилгүй иргэдэд мэргэжил сонгоход шаардлагатай ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээлэл, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлийн үйл ажиллагааг хөгжүүлэх гэжээ.

АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 8 дүгээр зүйлд заасны дагуу ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг хөгжүүлэх тогтолцоог бий болгох, хүүхэд залуучууд, ажилгүй иргэдэд өөрийн сонирхол, чадавх болон зах зээлийн эрэлтийг харгалзан ажил, мэргэжлээ сонгож, сурч эзэмших, ажил мэргэжлээрээ тасралтгүй өсөж хөгжихөд нь шаардлагатай ажил, мэргэжлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үзүүлэх замаар ажлын байранд зуучлах, тогтвортой ажлын байраар хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрагдах дор дурдсан зорилтот бүлгээс сонгогдсон иргэдийг хамруулна. Үүнд:

1. Аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажил хайгч хөдөлмөр эрхлэлтийн нэмэлт үйлчилгээ, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай зорилтот бүлгийн иргэд /өрх толгойлсон эмэгтэйчүүд , хүүхдээ асарч байгаа ажилгүй залуу эмэгтэйчүүд, сургууль төгсөөд 2-оос доошгүй жил ажилгүй байгаа залуучууд, төв суурин газарт шилжин ирсэн ажилгүй өрхийн гишүүд/
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд /харааны болон сонсголын бэрхшээлийн онцлогтой иргэд/
3. Хорих ангиас суллагдсан болон хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн
4. Зургаан сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа ажил идэвхтэй хайж байгаа сум, тосгонд амьдарч буй ажилгүй иргэн

5. Цэргийн хугацаат албанаас халагдсан иргэд, залуучууд
6. Хөдөө орон нутгийн МСҮТ-ийн төгсөх ангийн оюутан сурагчид
7. Хөдөө орон нутгийн сумдын болон алслагдмал суурин газрын ЕБС-ийн 6-12 ангийн суралцагчид
8. ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдын эцэг, эх, асран хүмүүжүүлэгч нар
9. Дээд боловсролтой, хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлттэй 25 хүртэлх насны ажил хайгч залуучууд
10. Ажил мэргэжлийн онлайн үйлчилгээнд хамрагдах ажил хайгч иргэд, хүүхэд, залуучууд

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үйлчилгээний төрөл

3.1. Хөтөлбөрийн хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд суурилсан хөдөлмөр эрхлэлтийн дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

3.1.1. Хөтөлбөрт хамрагдах 2,1-2,4 д заасан иргэдэд :

3.1.1.1. Хөтөлбөрт хамрагдах зорилтот бүлгийн иргэний өөрсдийнх нь онцлогт нийцсэн ажил, мэргэжлийн сонголт, чадвар, чадавхыг тодорхойлох аргачлалыг боловсруулж, ажил, мэргэжлийн сонголт, сургалт, боловсролын хэрэгцээг тодорхойлох

3.1.1.2. Хэрэгцээнд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөх үйлчилгээнд хамруулах

3.1.1.3. Хөдөлмөрийн болон нийгмийн харилцаа, хувь хүний зан төлөвшил, хандлагын өөрчлөлтийг бий болгох ерөнхий үр чадварын сургалтад хамруулж, мэдлэг, үр чадварын сорилоор тодорхойлолт гаргах

3.1.1.4. Шаардлагатай гэж үзвэл сэтгэл зүйн засал, зөвлөгөө өгөхөд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, сургалтад хамруулах / зөв амьдрах, дадал хэмнэлийн сургалт, бясалгал г.м /

3.1.1.5. Зорилтот бүлгийн иргэнийг тохирсон ажлын байранд зуучлах /job matching хийх /

3.1.1.6. Зорилтот бүлгийн иргэн тохирсон ажлын байранд зуучлагдах боломжгүй нөхцөлд шаардлагатай мэргэжлийн үр чадвар олгох олгох сургалтад хамруулж хувиараа хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хөтөлбөрт хамруулах

3.1.2. Хөтөлбөрт хамрагдах 2,5-2,8 –д засан иргэдэд:

3.1.2.1. Хөтөлбөрт хамрагдах зорилтот бүлгийн иргэдэд ажил, мэргэжлээ сонгох, ажил, мэргэжлийн талаарх ойлголт, танилцуулга, сурталчилгаа, сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг бүлгүүдийн онцлогт нийцүүлэн боловсруулж батлагдсаны сургалтын хөтөлбөр, модульд суурилан зохион байгуулах,

3.1.2.2. Ерөнхий боловсролын болон тусгай хэрэгцээт боловсролын 6-12 дугаар ангид мэргэжлийн чиг баримжаа олгох хичээлийг сургалтын хөтөлбөрт тусгаж, стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэх, хөдөө орон нутгийн сургуулиудад туршин нэвтрүүлэх,

3.1.2.3. МСҮТ-ийн төгсөх ангийн оюутан, залуучуудад үйлдвэрлэлийн технологи, горим, үйл ажиллагаатай аяллыг зохион байгуулж, шаардлагатай гэж үзвэл үйлдвэрлэлийн дадлага хийхэд ажил олгогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх,

3.1.2.4. Төгсөх ангийн сурагчдын эцэг, эх, асран хамгаалагч, хүмүүжүүлэгч нарт ажил мэргэжлийн сонголтод эергээр нөлөө үзүүлэхэд чиглэсэн хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, ажлын байрны захиалга, ажлын байранд тавигдах шаардлага, ажил мэргэжлийн талаарх танилцуулга сургалт, сурталчилгаа, зөвлөх үйлчилгээг үзүүлэх

3.1.2.5. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг ажил, мэргэжлийн салбар, мэргэжлийн онцлогт нийцүүлсэн үзүүлэх судалбарт болон видео, DVD, кино, мэргэжлийн тоглолт, үзэсгэлэн, яармаг, өдөрлөгийг зорилтот бүлгийн онцлогт нийцүүлэн зохион байгуулах

3.1.2.6. Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, ажлын агуулга, шинж чанарт гарч байгаа өөрчлөлт ажилтан хүний мэдлэг, чадварт тавигдах шинэ эрэлт шаардлага, хандлагыг тухайн орон нутгийнхаа онцлог, хүн ардынхаа амьдрал ахуйтай холбон зааж өгөх, сургах, зөвлөх орон нутгийн ахмад зөвлөх мэргэжилтэн, алдартнуудаар сургалт, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах

3.1.3 Хөтөлбөрт хамрагдах 2.9 –д засан иргэнд:

3.1.3.1. Хөтөлбөрт хамрагдах зорилтот бүлгийн иргэний өөрсдийнх нь онцлогт нийцсэн ажил, мэргэжлийн сонголт, чадвар, чадавхыг тодорхойлох аргачлалыг боловсруулж, ажил, мэргэжлийн сонголт, сургалт, боловсролын хэрэгцээг тодорхойлох, сонгон шалгаруулах

3.1.3.2. Хөтөлбөрт хамрагдах дээд боловсролтой, хувиараа аж ахуй эрхлэх хүсэлттэй иргэний аж ахуй эрхлэх боломж, чадавхыг тусгайлсан ерөнхий мэдлэг, чадварын сорилын үр дүнгээр тодорхойлж, хувиараа хөдөлмөр эрхлэх, бизнес санаагаа

боловсруулж, төсөл боловсруулах болон аж ахуй эрхлэлтийн тусгайлсан сургалтад хамруулах. Тусгайлсан сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

3.1.3.3. Хувиараа аж ахуй эрхлэх хүсэлттэй иргэнийг аж ахуй эрхлэлтийн тусгайлсан сургалтад хамруулсны дараа тухайн бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь мэргэжлийн зөвлөгөө өгөх мэргэшсэн зөвлөхтэй гэрээтэй ажиллуулах ба мэргэшсэн зөвлөхөөр өгөх зөвлөгөө мэдээлэл нь тухайн аж ахуй эрхлэх чиглэлээр шинэ техник, технологи, инновацыг нэвтрүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээнд дэх хөдөлмөрийн харилцаа, төлөвшил, хандлагыг олгоход чиглэнэ. Сургалт, зөвлөгөө, мэдээлэл нь үйлдвэрлэл дээрээ дагалдуулах сургалтын зарчмаар зохион байгуулагдана. Сургалт, зөвлөгөө, мэдээлэлтэй холбогдон гарах зардалд санхүүгийн дэмжлэг олгоно.

3.1.3.4. Хөтөлбөрт хамрагдах зорилтот бүлгийн иргэдээс нийгмийн үйлчилгээний чиглэлээр ажил мэргэжлээ өөрчлөн сонгох хүсэлтэй залуучуудаас сонгон шалгаруулж дипломын дараах боловсрол олгох нэг жилийн ангид түршилтаар сургалтад хамруулах сургалтыг Удирдлагын академитай хамтран хэрэгжүүлнэ.

3.1.4 Хөтөлбөрт хамрагдах 2,10-д заасан иргэдэд зориулсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээний доорх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

3.1.4.1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ үзүүлэх цахим апплэйкэшн боловсруулж, сүлжээнд байршуулах,

3.1.4.2. ЕБС суралцагчдад зориулсан өөрийн сонирхол, чадавхаа таньж мэдэх, ирээдүйн мэргэжлээ сонгоход туслах онлайн сүлжээ, апп –уудыг бий болгох,

3.1.4.3. Их, дээд сургууль төгсөгчид, МСҮТ төгсөгчид, сургуулиа төгсөөд удаагүй, ажилгүй байгаа иргэдэд зориулсан ерөнхий мэдлэг, үр чадварыг тодорхойлох оношилгоо, сорилын онлайн болон мэргэшсэн төвүүдийг байгуулж, хөндлөнгийн үнэлгээ гаргах,

3.1.4.4. Үндэсний хэмжээний ажил мэргэжлийн лавлагаа, тодорхойлолт гаргах мэргэжлийн мэдээллийн нэгдсэн санг бий болгож, сүлжээнд байршуулах,

3.1.4.5. Сонгосон аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс, хөдөлмөрийн биржид “Мэргэжлийн мэдээллийн жишиг төв байгуулах,

3.1.4.6. Мэргэжлийн мэдээллийн дата баазуудыг макро эдийн засгийн түвшинд болон салбарын, орон нутгийн түвшинд боловсруулж, нэгдсэн санг цахим сүлжээнд байршуулах,

3.2. Хөтөлбөрт заасан мэргэшүүлэх сургалт болон тусгайлсан сургалтыг мэргэжлийн эрх бүхий сургалтын байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, сургалтын зардал, ажлын хөлсийг зохих журмын дагуу олгоно.

3.3. Хөтөлбөрийн арга хэмжээнд оролцох зөвлөхүүдийг сургах, мэргэшүүлэх, зөвлөх үйлчилгээ эрхлэх эрхийг ХЭҮСМҮ Төвөөс олгож, нэгдсэн санг бүртгэж авна

3.4. Залуучуудын аж ахуй эрхлэхтэй холбогдсон зөвлөхийн үйлчилгээг мэргэшсэн зөвлөгөө өгөх консалтингийн компанийг сонгон арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.5. Үндэсний хэмжээний мэргэжлийн мэдээллийн санг ХЭҮСМҮ Төвийн хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн санд байршуулж, мэдээллийг боловсруулах, цуглуулах, түгээх ажлыг хариуцна.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, санхүүжилт

4.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг ХЭҮСМҮТөв арга зүйн удирдлагаар хангаж, сонгосон аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс, хөдөлмөрийн биржид түршин хэрэгжүүлнэ.

4.2 Хөтөлбөрийн хүрээнд иргэнд үзүүлж буй бүх төрлийн сургалт, зөвлөх үйлчилгээ, санхүүгийн дэмжлэг олгох, мэдээллийн нэгдсэн санг бий болгох арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг уг хөтөлбөрт заасан нөхцөл болон холбогдох журмын дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

4.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө, төсвийг Хөдөлмөрийн сайдаас хуваарилсан төсвийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн Үндэсний төвийн захирал баталж мөрдүүлнэ.

4.4 ХЭҮСМҮ Төвийн хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хэлтэс энэхүү хөтөлбөрийн зохион байгуулалт, арга зүй зохицуулалтаар хангаж ажиллах бөгөөд бүтцэдээ мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний мэдээлэл, лавлагааны төвийг байгуулна.

Тав. Хөтөлбөрийн тайлагналт, үр дүн

5.1 Хөтөлбөрт хамрагдсан аймаг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэс, хөдөлмөрийн бирж нь хэрэгжилтийн сарын тайлан, мэдээг дараа сарын 3-ны дотор, улирлын мэдээг дараа улирлын эхний сарын 3-ны дотор Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ,судалгаа, мэдээллийн Үндэсний төвд, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ,судалгаа, мэдээллийн Үндэсний төв тайлан мэдээг ажлын 3 хоногт багтан нэгтгэн дүгнэж Хөдөлмөрийн яаманд тус тус хүргүүлнэ.

5.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг дор дурдсан шалгуураар дүгнэнэ. Үүнд:

- Хөтөлбөрийн хэрэгжилтээр зохистой, тохирсон ажлын байранд зуучлан тогтвортой ажлын байраар хангагдсан зорилтот бүлгийн иргэдийн тоо
- Ажил эрхлээгүй залуучуудаас хувиараа аж ахуй эрхэлсэн иргэний тоо
- Мэргэжлийн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгож, мэдээллийн лавлагаа өгөх төвүүдийг байгуулсан байх

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээнд суурилсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоо бий болгосон байх зэрэг өргөн хүрээнд олон асуудлыг тусгасан боловч хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг тооцсон мэдээлэл судалгааны баримт материал байхгүй байна.

Улсын их хурлын 2015 оны 12-р тогтоолоор “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024) баталсан бөгөөд энэ бодлогын 3.5 хэсэгт бүрэн дунд боловсролыг “Сонголттой, уян хатан хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадвар бүхий, ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь баримжаа олгох үе хэмээн хөгжүүлнэ” гэж заажээ.

2016 оны 6 сарын 24-ний өдөр Хөдөлмөрийн болон БСШУ-ны сайдын хамтарсан тушаалаар “Ажил мэргэжлийг чиг баримжааг хөгжүүлэх” чиглэлийг баталсан. АМЧБО үйлчилгээ нь “иргэн бүрийн насан туршдаа сурч боловсрох, ажил хөдөлмөрийн сонголтоо хийх, ажил мэргэжлийн замаа удирдан хөгжүүлэх, мэргэжлээрээ тасралтгүй өсөж хөгжихөд нь туслах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт, арга зүйн удирдлагын нэгдмэл тогтолцоо бүрдүүлэх” зорилготой.

Стандартчиллын Үндэсний зөвлөлөөс 2016 оны 6-р сарын 23-ны 39 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага стандартын MNS6620:2016”-г баталсан ба Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газраас үүний дагуу “Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх ажилтанд тавигдах нийтлэг шаардлага”-ыг тодорхойлсон байна. Дээрх ажил, үйлчилгээг үзүүлэх ажилтан дараах шаардлагыг хангасан байна гэж заасан. Тухайлбал: Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх ажилтан сэтгэл судлал, хүний нөөцийн удирдлага, эдийн засаг, санхүү, сурган заах арга зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн ажлын чиглэлээр бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлийн үйлчилгээ үзүүлэх сургалтад хамрагдаж мэргэшсэн байна. Үнэлгээ мэдээллийн төвийн хөндлөнгийн үнэлгээнд хамрагдаж, үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн зөвлөхийн гэрчилгээтэй байна. Ажлын туршлага, харилцаа хандлага, үр чадварын хувьд хүнтэй ажиллах арга барилд суралцсан, боловсрол, нийгэм, хөдөлмөр эрхлэлтийн салбарт ажиллаж байсан, мэргэжлийн харилцааны соёлыг эзэмшсэн, зөв төлөвшилтэй, хувийн сахилга баттай, ажил гүйцэтгэх

чадвартай, бичгийн боловсрол өндөр, мэргэжлийн тусгай шаардлагуудыг хангасан байна. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтний ажлын байрны жишиг тодорхойлолтыг баримтлан ажиллана.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох “Хөдөлмөр сургалтын танхим” түршилтын төслийг хэрэгжүүлэх удирдамж батлах тухай ХНХ-ын сайд, БСШУС-ын сайдын 2020 оны 4 дүгээр сарын 06-ний өдрийн А/88, А/178 дугаар хамтарсан тушаал гаргалаа. Энэхүү түршилтын төсөл нь ЕБС-ийн 8-12 дугаар ангийн суралцагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн анхан шатны үр чадвар олгох, хөдөлмөрт бэлтгэх, гарын үр дүйг хөгжүүлэн дэмжих, дадлагажуулах үйл ажиллагааг зохион байгуулах орчин нөхцөл бүхий танхимыг төрийн болон орон нутгийн өмчийн сургуулиас ирүүлсэн саналд үндэслэн сонгон шалгаруулж байгуулна. Тушаалын хэрэгжилт, үр дүнг тооцсон талаар мэдээллийн илэрц байхгүй байна.

Засгийн газрын 2019 оны 162 дугаар тогтоолоор батлагдсан шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 3.1.2. ахлах ангийн сурагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох арга хэмжээг тогтмол зохион байгуулах замаар залгамж халаа бэлтгэх санал, санаачилгыг дэмжих гэж заажээ.

ХХҮҮГ-аас ажил хайгч залуучуудын эрэлт хэрэгцээнд тохирсон үйлчилгээ үзүүлж, ХЗЗ-д идэвхтэй нэвтрэн ороход нь туслах зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн албад, хөдөлмөрийн биржүүдээс тухайн ажил хайгчийн хувийн чадамж, хөдөлмөр эрхлэхэд учирч буй саад тотгорыг илрүүлж, хөдөлмөрийн зах зээлд ойр эсвэл алслагдмал байгааг нь тодорхойлон, удаан хугацаагаар ажилгүй байх эрсдэлийг нь үнэлэхэд ашиглах зорилгоор аргачлал, маягт боловсруулан баталжээ. Энэхүү аргачлалыг Швейцарын хөгжлийн агентлагийн “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн дэмжлэгтэйгээр боловсруулж түршсан байна.



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 9/23

Улаанбаатар хот

Аргачлал, маягт батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг 2019-2020 онд хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж батлах тухай" 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн А/83 дугаар тушаалын 2 дугаар заалт, уг тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж"-ийн Хоёрдугаар бүлгийн 2.3.1.3, 2.3.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Ажил хайгч залуучуудын хөдөлмөр эрхлэх чадварыг үнэлэх аргачлал (Үнэлгээ хийх маягт, маягтыг бөглөх заавар бүхий)-ыг нэгдүгээр, Ажил хайгч залуучуудын хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх аргачлал (Төлөвлөгөөний загвар, заавар бүхий)-ыг хоёрдугаар, Ажил хайгч залуучуудын хамтын ажиллагааг дэмжих үйлчилгээний хүрээнд үе шаттай (модуль) сургалт зохион байгуулах аргачлал (жишиг хөтөлбөр бүхий)-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар /Ч. Саналбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Б.НЯМДАВАА

АМЧБО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОЛОН УЛС НӨХЦӨЛ БАЙДАЛ

Ажил мэргэжлийн чиг баримжаа тухайн улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой Дэлхийн улсууд ажил мэргэжлийн чиг баримжааг боловсрол, сургалтад үр ашигтай хөрөнгө оруулалт хийх (сургууль завсардалтыг бууруулах, сурлагын амжилтыг дээшлүүлэх гэх мэт), хөдөлмөрийн зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх (хөдөлмөрийн зах зээлийн эрэл, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх, эдийн засгийн хувьд оновчтой үр чадвартай ажилтантай байх гэх мэт), нийгмийн эрх тэгш байдлыг хангах гэх мэт төрийн бодлогын зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх бодлогын арга хэрэгсэл гэж үзэж байна.

АНУ ерөнхий боловсролын сургуульд бага ангиас эхлэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааг хамгийн сайн хэрэгжүүлдэг улс орнуудын нэг юм. Дэлхийн олон орон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг хэрэгжүүлэхдээ АНУ-ын бэлтгэн гаргасан материалыг хэрэглэх нь түгээмэл байдаг байна.

АНУ, Канад, Их Британи, Шинэ Зеланд, Австрали, Өмнөд Солонгос, Сингапур, Япон зэрэг орнуудын хөтөлбөрийг судалж үзэхэд засгийн газар, яам нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын талаар тодорхой бодлого, хөтөлбөртэй зарим нь бие даасан хичээл, багштай байдаг бол нөгөө хэсэг нь тодорхой хичээлийн агуулгын хүрээнд багтаан хүүхэд бүр судлахаар баталсан байна. Эдгээр орнуудад тус хичээлээр суралцагчдыг өөрийгөө танин мэдэх, хичээл сургалтыг өөрийн эзэмших боловсрол, ажил мэргэжлийн боломжуудтай холбон ойлгох, хөдөлмөрийн зах зээлд шинээр бий болж байгаа ажил мэргэжилтэй танилцах болон насан туршдаа сурч боловсрох дадал чадварыг эзэмших боломж олгодог байна. Гадаадын зарим хөгжингүй орнууд, тухайлбал Австрали, Сингапурт сүүлийн үед мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд хувь хүний хөгжлийн асуудлыг илүүтэй анхаардаг болж эхэлж байна.

Япон улс 1949 онд Боловсролын сайд нь дунд сургуулийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр батлан одоог хүртэл бие даасан хичээл болон сургалтыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж иржээ. Тус хичээлийг

1. ажил мэргэжлийн төлөвлөлт хийх
2. ажил мэргэжлийн мэдээлэл цуглуулах, хэрэглэх
3. шийдвэр гаргах
4. хүмүүстэй харилцах гэсэн 4 чиглэлийн хүрээнд 12 чадвар эзэмшүүлэхээр бага, дунд, ахлах ангийн түвшинд хэрэгжүүлж байна.

Жишээ нь, “Хүмүүстэй харилцах” гэсэн чиглэлийн хүрээнд:


- Бага ангид: “өөрийнхөө талаар ойлгох болон бусдыг хүндлэхийн ач холбогдлыг мэдэх, өөрийн бодол санаа хэрхэн өөрчлөгддөг яагаад энэ нь чухал болохыг ойлгох”
- Дунд ангид: “өөрийнхөө хүчтэй талыг мэдэж, бусдад хэрхэн нөлөөлж болох талаар ойлгож мэдэх, өөрийн бодол, санааны өөрчлөлтийг ойлгож мэдэх, энэ нь яагаад чухал болохыг ухамсарлах, хүмүүстэй харилцаа тогтоох”
- Ахлах ангид: “өөрийнхөө хүчтэй талыг ойлгох, өөрийн зан төлөв нөлөөлөл болон ажил мэргэжлийн холбоо хамаарлыг таньж мэдэх, өөрийн бодол, санааны өөрчлөлтийг ойлгож мэдэх, энэ нь яагаад чухал болохыг ухамсарлах, бусадтай үр дүнтэй харилцах чадвар эзэмших” гэж тус тус тодорхойлсон байна.

Бусад орны туршлагаас харахад сургалт болон үйлдвэрлэлийг үр дүнтэй холбох чухал арга хэрэгсэл нь МБСБ-д суралцаж буй суралцагчдад сургалтын эхний өдрөөс эхлэн мэргэжлийн чиг баримжааг олгох үйлчилгээг байнга үзүүлж суралцагч сонгож орсон мэргэжилдээ дур сонирхолтой болох, мэргэжлийн дагуу өөрийн карьер хөгжлийг үр дүнтэй төлөвлөх үйл

явцыг чиглүүлж өгснөөр зах зээлийн шаардлагад бэлэн ажиллах хүчин бэлтгэн гаргадаг байна.

Finland

In Finland in vocational education and training all students will have their own personalization plan for own studies. This type of planning gives several options how to implement studies. One option is to choose skills competition as a learning pathway.



The Ministry of Education and Culture publication Finnish education in a nutshell says following - Skills competitions encourage both the young and adults to consider VET as a viable, attractive option. They are also an important tool for developing and benchmarking VET. Finland participates in WorldSkills, EuroSkills and Abilympics. Also, a national skills competition called Taitaja is organised annually.

Participating in skills competitions is an excellent way to develop the expertise of the personnel of the education organizers, offer students individual learning paths and develop the operational activities of the entire organization.

Гадаад орнуудын ижил төстэй вэб сайтуудыг судалсан байдал:

Солонгос, Япон, Герман, Австрали зэрэг орнуудын ижил чиглэлийн цахим хуудастай танилцан туршлага судлахад Австрали, Өмнөд Солонгос, Сингапурын жишээн дээр суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг хэрхэн хүргэж байгааг тандан судалж тухайн улс, орнуудын мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын асуудлыг цогц, дэлгэрэнгүй байдлаар хамраагүй болно.

Нийтлэг дараах асуудлуудыг хамарсан. Үүнд:

- Улс орнуудын туршлагаас харахад ажил мэргэжлийн чиг баримжааны нэр томьёо өөр өөрөөр хэрэглэгдэж байна. Жишээлбэл ажил мэргэжлийн чиг баримжаа (career guidance), карьер хөгжлийн төлөвлөгөө (career development plan) болон эдгээр нэр томьёог хамтад нь хэрэглэж байгаа бөгөөд эдгээр нэр томьёо өөр өөр утгыг илэрхийлж байдаг байна.
- Бусад орнуудын туршлагыг авч үзэхэд засгийн газраас санхүүгийн болон бусад дэмжлэгийг хэрхэн үзүүлж байгаа нь улс бүрд харилцан адилгүй байна. Жишээлбэл, өмнөд Солонгост сүүлийн жилүүдэд ажил мэргэжлийн боловсрол болон чиг баримжаа олгох сургалтад их хэмжээний санхүүжилт хийсэн байна.
- Зарим улсуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг Засгийн газар нь манлайлан хэрэгжүүлдэг байхад заримд улсад сургууль эсвэл хувь хүмүүс гардан хэрэгжүүлдэг байна.

Австрали¹

Австралид мэргэжлийн чиг баримжаа олгох боловсролын үүрэг хариуцлагыг 8 муж, тойргууд өөр өөрсдөө хариуцдаг. Тиймээс эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй арга болон ашиглаж буй материал нь өөр өөр байдаг.

Зарим мужуудад ажил мэргэжилтэй холбоотой зөвлөх эсвэл сургуулийн сэтгэл зүйчдийн хүлээж буй үүрэг хариуцлага өөр өөр байдаг. Тэд суралцагчдын боловсрол, халамж, зан үйл болон ажил мэргэжилтэй холбоотой зөвлөгөө өгдөг. Хэдийгээр тэд маш сайн сургагдсан байдаг боловч ажлын цагийнхаа дөнгөж 30 хүрэхгүй хувийг ажил мэргэжилтэй холбоотой үйл ажиллагаанд зарцуулдаг.

Бусад муж болон тойргуудад хэдэн зөвлөх эсвэл мэргэжлийн чиг баримжаа олгох асуудал хариуцсан ажилтанг ажиллуулах асуудлыг өөрсдөө шийддэг. Тиймээс сургууль бүр харилцан адилгүй ажилтантай байдаг. Сургуулиуд нэг сурагчид анхаарал хандуулахаас илүүтэй анги ангиар нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх хандлагатай байдаг.

Харин Викториа муж улсын Засгийн газар мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын удирдамж, сургалтын материал боловсруулж сургуулиудад хэрэгжүүлдэг. Тэнд өндөр түвшинд мэргэшсэн баг ажилладаг бөгөөд сургуулиуд, тэдний ажил мэргэжлийн зөвлөхүүдэд маш сайн дэмжлэг үзүүлдэг. Энэ үйл ажиллагааны цаана мэргэжлийн байгууллагууд ажилладаг ба тэдний нэг нь Викториа мужийн ажил мэргэжлийн

¹ <http://cica.org.au/the> Career Industry Council of Australia

боловсролын холбоо юм. Энэ холбоо өргөн хүрээний сургалт зохион байгуулж, мэргэжлийн хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Тус холбоо нь ажил мэргэжлийн чиглэлээр янз бүрийн үйл ажиллагаа явуулж, түүний хүрээнд олон төрлийн материал, гарын авлага боловсруулдаг. Үүнд үндэсний хэмжээнд ажил мэргэжлийн долоо хоног, Ажил Мэргэжлийн Тоглоом нэртэй үндэсний хэмжээний танилцуулах аян, үндэсний хэмжээний ажлын хэсэг байгуулж ажил мэргэжлийн боловсролын удирдамж боловсруулах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр ажилладаг мэргэжилтэн, судлаачид, бодлого боловсруулагчдад зориулан олон улс болон үндэсний хэмжээний форум зохион байгуулах, Австралийн Ажил Мэргэжлийн Салбарын Хороог байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаанууд багтдаг. Эдгээрээс дөрвийг нь жишээ болгон авч үзье. Үүнд:

1) Австралийн Ажил Мэргэжлийн Салбарын Хороо²

Энэ хороо нь ажил мэргэжлийн боловсрол хариуцсан мэргэжилтэн, судлаачдын хамгийн том байгууллага бөгөөд бүхий л салбарт олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Хамгийн гол ажил нь энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг мэргэжилтэн, судлаачдад зориулсан стандартыг гаргасан бөгөөд энэ стандартыг мөрдөхтэй холбоотой сургалтуудыг зохион байгуулдаг.


Мэргэжлийн Стандарт нь Австралийн ажил мэргэжлийн боловсролын үндсэн баримт бичиг бөгөөд норм болдог. Мэргэжлийн стандарт нь:

- Ажил мэргэжлийн салбар, түүний гишүүнчлэл болон үйлчилгээ, үйл ажиллагааг тодорхойлох;
- Энэ чиглэлийн мэргэжилтэн судлаачдын төрөл бүрийн мэдлэг, чадварыг илрүүлэх;
- Энэ чиглэлийн мэргэжилтэнг аж үйлдвэрийн салбарт орж ажиллахад чиглүүлэх;
- Ажил мэргэжлийн боловсролын сургалтыг төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх;
- Ард нийт болон хамтран ажиллагсдад чанарын баталгаа хангах;
- Ажил мэргэжлийн мэргэжилтэнг үнэлэх, дүгнэх үндсэн бенчмарк гаргах;
- Энэ чиглэлийн мэргэжилтний тасралтгүй хөгжих, сургалтад хамрагдахыг шаардах;
- Аж үйлдвэрийн салбарын нэр томьёог нэг түвшинд боловсруулан гаргах

Энэ холбоо нь өөрийн гэсэн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээний журамтай байдаг. Журамд мэргэжлийн стандарт нарийн тусгагдсан байдаг.

² <http://cica.org.au/the Career Industry Council of Australia>

2) Австралийн Ажил мэргэжлийн боловсролын блюпринт³



Австралид Засгийн газар нь улсын хэмжээний ажил мэргэжлийн үлгэрчилсэн хүрээтэй байх нь ач холбогдолтой гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Иймээс энэ хүрээг боловсруулах ажлыг Майлас Морган компани хийж гүйцэтгэсэн ба Канадын блюпринт дээр үндэслэсэн. Австралийн ажил Мэргэжлийн Блюпринт гарч, Австрали даяар хэрэгжсэн түүхтэй. Энэ хүрээ нь 3 айтай ба

нийтдээ 11 чадамжтай байдаг. Энэхүү 3 айн 11 чадамжийг 4 үе шаттай хөгжүүлэхээр төлөвлөсөн байдаг.

Хүснэгт 7. Австралийн Ажил Мэргэжлийн блюпринт⁴

Суралцах ай	Чадамжууд
Хувийн менежмент	1. Өөрийнхөө талаар эерэг хандлагатай байх 2. Бусадтай эерэг, үр дүнтэй харилцах 3. Амьдралын туршид өөрчлөгдөх, өсөж хөгжих
Сурах болон ажиллах үйл ажиллагаанд оролцох	4. Ажил мэргэжлийн зорилгод дэмжлэг болох насан туршийн боловсролоор сурах 5. Ажил мэргэжлийн мэдээллийг оновчтой байршуулах, үр дүнтэй ашиглах

³ <https://www.education.gov.au/australian-blueprint-career-development> The Australian Blueprint for Career Development (ABCD)

	6. Ажил, нийгэм болон эдийн засгийн холбоо хамаарлыг ойлгох
Ажил мэргэжил эрхлэх	7. Ажлын аюулгүй байдлыг ханган ажиллах
	8. Ажил мэргэжилдээ дэвших шийдвэр гаргах
	9. Ажил, амьдралын үүрэг хариуцлагын тэнцвэрийг хангах
	10. Ажил, амьдралын үүрэг хариуцлага өөрчлөгдөж байдгийг ойлгох
	11. Ажил мэргэжлээрээ дэвших, өсөх үйл явцыг ойлгох, түүнд идэвхтэй оролцох болон удирдах

Дээр дурдсан 11 чадамжийг 4 үе шат тус бүрээр боловсруулсан тул нийтдээ 44 чадамж байна гэсэн үг. Энэ 44 чадамж тус бүрд харгалзах үйл ажиллагааны зөвлөмж нэг бүрчлэн боловсруулагдсан байдаг тул маш нарийвчлан боловсруулсан хөтөлбөр гэж үзэж болно.

3) Ажлын хөтөч⁵

Ажлын хөтөч гэдэг нь Австралийн Засгийн газраас боловсруулсан Австрали улсын 500 ажил мэргэжлийг танилцуулсан нэлээд дэлгэрэнгүй баримт бичиг бөгөөд жил бүр шинэчлэн сургуулиудад хүргүүлдэг. Мөн нийтэд зориулан худалдаанд бас гардаг. Энэ ажлын хөтөч нь ажил мэргэжлийн мэргэжилтэн, зөвлөхүүдэд, сургуулиудад энэ чиглэлээр сургалт явуулахад, хувь хүмүүст өөрсдийн ажил мэргэжлийн судалгаа хийхэд маш хэрэглэгддэг. Саяхнаас хэвлэмэл хувь хэрэглэхийг зогсоон хэвлэлийн хувийн компанийг онлайн хэлбэрээр олон нийт, сургуулиудад түгээх үйл ажиллагааг хариуцан ажиллуулдаг болсон.

4) Миний ирээдүй⁶

Засгийн газраас ажил мэргэжлийн хөгжлийн чиглэлээр вэбсайт хөгжүүлэх, боловсруулах ажлыг хариуцсан бие даасан байгууллага байгуулсан. Энэ нь үнэгүй вэбсайт бөгөөд суралцагчид бүртгүүлээд "Ирээдүйгээ томьёолох" хэсэг рүү нэвтэрч ажиллах боломжтой юм. Энэ нь 7 бүрэлдэхүүнтэй. Үүнд:

- *Ажил мэргэжлийн хавтас үүсгэх:* Энэ нь суралцагчдад өөрийн сонирхол, чадвараа нээж илрүүлэх, түүндээ тохирсон ажил мэргэжлийн талбараа тодорхойлох, илүү гүнзгийрүүлэн судлах боломжийг олгодог.

⁵ <http://www.education.gov.au-job-guide>The Australian Government Job guide

⁶ <http://myfuture.edu.au/My> Future Australia

- *Ажил, мэргэжлүүдийг олж мэдэх:* Энэ хэсэг ажил мэргэжлийн талаар нарийвчилсан мэдээллийг агуулдаг.
- *Ажлын байран дээрх нөхцөл байдлын талаар олж мэдэх:* Энэ нь суралцагчдад ажлын байран дээрх нөхцөл байдлын талаар мэдээлэл олоход тусалдаг.
- *Ажил мэргэжлийн ертөнцийг таних:* Ажил мэргэжилтэй холбоотой төрөл бүрийн зөвлөгөө байдаг.
- *Сургалт хайх:* Суралцагчдад Австралид байдаг сургалтуудын талаар нарийвчилсан мэдээлэл өгдөг.
- *Кейс унших:* Энд бодит амьдралд тохиолдож байсан кейс, жишээ баримтыг бичсэн байдаг.
- *Компани сонгох:* Тухайн сонгосон компанид байдаг ажил мэргэжил, ажлын байртай холбоотой мэдээллүүд байдаг.

5) Бусад холбогдох эх сурвалж материал

Хөдөлмөрийн яамнаас Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн портал⁷ ажиллуулдаг. Энэ портал нь хөдөлмөрийн зах зээл, сул орон тооны мэдээлэл болон сүүлийн үеийн чиг хандлагын талаар нарийвчилсан мэдээллийг багтаасан байдаг.

Түүнчлэн ажил мэргэжилтэй холбоотой өөр олон вэбсайт байдаг ба ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжилтэн, зөвлөхүүд их ашигладаг. Миний ирээдүй, ХЗЗ-ийн мэдээллийн портал (нэгдсэн сан)-ын давуу тал нь эдгээрийг Засгийн газар баталсан байдагт оршдог. Тиймээс илүү шинэлэг, нарийвчилсан, алдаа мадаггүй, ашиг сонирхлын зөрчил ороогүй, бодит мэдээлэлтэй байдаг тул хэрэглэгчдэд онлайнаар мэдээлэл авах боломжийг олгодгоороо ач холбогдолтой юм.

Үүнээс гадна муж улсууд өөр өөрийн гэсэн мэдээллийн эх сурвалж материалуудтай байдаг.

Өмнөд Солонгос⁸

2014 оны 7 сард Сөүл их сургуульд олон улсын ажил мэргэжлийн боловсролын 3 дугаар эрдэм шинжилгээний хурал болсон юм. Энэ хурал "Суралцагчдад ажил мэргэжлийн боловсрол олгохын тулд тэдний ажил мэргэжлийн ертөнцийг нээж илрүүлэх үйл ажиллагаанд ажил олгогчдын оролцоог дэмжье" сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж дараах чиглэлүүдэд анхаарлаа хандуулсан:

Өмнөд Солонгос улс ажил мэргэжлийн боловсролын хөтөлбөрт их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа. Солонгост сургуулиудийн сургалтын үйл ажиллагаагаар дамжуулж ажил мэргэжлийн боловсролыг олгох замаар тогтолцоог хөгжүүлэхэд анхаарч байгаа

⁷ <https://www.education.gov.au/career-bullseye-posters>

⁸ <https://www.google.com/search?q=career+education+south+korea>



бөгөөд энэ чиглэлийн мэргэжлийн багш нарыг сургуулиудад ажиллуулах болсон байна. Түүнчлэн ажил мэргэжлийн сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулийн санаачилсан ажил мэргэжлийн боловсрол гэсэн үнэгүй хөтөлбөрийг сургуулиудад хэрэгжүүлэх болсон. Мөн онлайн хэлбэрээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. Одоо нийт сургуулиудын 84хувь нь ажил мэргэжлийн боловсрол

хариуцсан багштай болсон. 2009 онд ажил мэргэжлийн боловсролын бодлогыг сургуулиудад хэрэгжүүлснээр ажил мэргэжлийн боловсролын дэлгэрэнгүй төлөвлөгөөтэй болсон нь ажил мэргэжлийн боловсрол өнгө төрхөө олоход их хувь нэмэр оруулсан. Энэ төлөвлөгөөг БШУТЯ, хөдөлмөрийн яам, болон эрүүл мэнд, халамжийн яам хамтран боловсруулж баталсан.

Ажил мэргэжлийн боловсролын төлөвлөгөө нь 3 чиглэлийн 10 даалгавартай - (i) сургуулийн түвшинд туршилтад түшиглэсэн ажил мэргэжлийн боловсролын үйл ажиллагааг идэвхжүүлэх, (ii) ажил мэргэжлийн боловсролын үйлчилгээг тэгш хүргэх, (iii) ажил мэргэжлийн боловсролд дэмжлэг үзүүлэх тогтолцоог төгөлдөржүүлэх.

Сургуулийн түвшинд туршилтад түшиглэсэн ажил мэргэжлийн боловсролын үйл ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд:

- ажил мэргэжлийн болон мэргэжлийн сургалтын дадлага туршилтын хөтөлбөрийг бэхжүүлэх
- "ажил мэргэжлийн" 7 хоног зохион байгуулах, өргөжүүлэх
- ажил мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн шилдэг туршлагыг дэлгэрүүлэх, шилдэг сургуулийг гэрчилгээжүүлэх, энэ чиглэлийн сурах бичиг, гарын авлага боловсруулж, түгээх

Ажил мэргэжлийн боловсролын үйлчилгээг тэгш хүргэх үйл ажиллагааны хүрээнд:

- эмзэг бүлгийн залуучууд болон эрсдэлтэй бүлгийн иргэдийн ажил мэргэжлийн боловсролыг бэхжүүлэх

- олон-соёлт бүлгийн болон хойд солонгосын дүрвэгч залуучуудын ажил мэргэжлийн боловсролыг өргөжүүлэх
- сургууль завсардсан суралцагчдад зориулан ажил мэргэжлийн боловсролын орчин бий болгох, өөртөө итгэж найдах тогтолцоог бий болгох

Ажил мэргэжлийн боловсролд дэмжлэг үзүүлэх тогтолцоог төгөлдөржүүлэх үйл ажиллагааны хүрээнд:

- ажил мэргэжлийн мэдээллийн тогтолцоо бий болгох, удирдах
- ажил мэргэжлийн боловсролтой холбоотой хууль эрх зүй, байгууллагуудын шинэчлэл хийх
- ажил мэргэжлийн боловсролын мэргэжилтнүүдийг сургах, сургалтын тогтолцоог дахин төлөвлөх

Ажил мэргэжлийн боловсролын санаачлагуудыг дэмжих зорилгоор Боловсролын яам нь өргөн хүрээнд судалгаа шинжилгээний ажил хийж буйн нэг жишээ нь Солонгосын мэргэжлийн боловсрол, сургалт судалгааны хүрээлэнг байгуулсан. Тус хүрээлэнгийн зорилго нь бусад улсын туршлага болон судалгааны материалд дүн шинжилгээ хийх, шинжээч багш нарын төлөөлөл бүхий зөвлөх баг байгуулах, ажил мэргэжлийн боловсролын төв байгуулах болон ажил мэргэжлийн боловсролын багш нарын стандартын дагуу ажиллаж байгаа эсэхэд үнэлгээ, дүгнэлт хийхэд оршино.

2015 оны 7 сард Ажил мэргэжлийн боловсролын хууль батлагдаж, хэрэгжиж эхэлсэн ба энэ нь голчлон сургуулийн ажил мэргэжлийн боловсролын хөтөлбөр, түүний хэрэгжилтийг дэмжихэд чиглэсэн байдаг юм. Ажил мэргэжлийн боловсролыг дараах 3 шалтгааны улмаас ач холбогдолтой гэж үзсэн байна.

1. Сургуулийн боловсрол ажил мэргэжилтэй төдийлөн сайн холбогдохгүй байна.
2. Олон суралцагчид ажил мэргэжлийн онцлог сонирхлоо төдийлөн сайн ойлголгүйгээр их дээд сургуульд орж ирдэг.
3. Ажил мэргэжлийн боловсролын салбар дахь эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг хэрхэн зохицуулах, коллежид сурах эрмэлзлийг багасгах , эсвэл ажил мэргэжлийн боломжийг нэмэгдүүлэх эсэхэд шийдэх.

Дээрх асуудлын хүрээнд Солонгосын Засгийн газар, сургуульд ажил мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагаанд их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн ба ингэхдээ суралцагчдын ажил мэргэжлийн ертөнцийг нээж илрүүлэх, туршлага судлахад голчлон анхаарсан. Ингэснээр сургуулиуд суралцагчдыг ажлын байран дээр очиж танилцуулах, ажил мэргэжлийн зусланд хамруулах, ажлын үзэсгэлэн, яармаг зохион байгуулах зэрэг олон

ажлын тогтмол зохион байгуулдаг болсон. Ингэснээр, ажил мэргэжлийн боловсрол шинэ түвшинд гарсан бөгөөд дараах томоохон үр дүнд хүрсэн.

- 2009 онд "ажил ба мэргэжил" хичээл нь сургуульд заах үндсэн хичээлүүдийн нэг болсон.
- 2011 онд ажил мэргэжлийн багш нар ахлах сургуулиудад хуваарилагдан ажиллах болсон.
- 2012 онд боловсролын яамнаас ажил мэргэжлийн боловсролын зорилгыг томъёолж, түүний стандартыг боловсруулсан. Ажил мэргэжлийн боловсролын чанарыг сайжруулах зорилгоор энэ сургалтыг сайжруулах хөтөлбөрийг зарласан. Дунд сургуулиуд ажил мэргэжлийн боловсрол олгох багштай болсон.
- 2013 оны байдлаар нийт сургуулийн 84 хувь нь ажил мэргэжлийн боловсрол олгох багштай байх хэрэгцээ байгааг тодорхойлсон байна. Сургуулиуд ажил мэргэжлийн боловсрол ямар чиглэлээр олгож байгаагаасаа шалтгаалан ангилагдах болсон. Суралцагчид суурь чадварыг хөгжүүлэх болон ажил мэргэжлийн төлөвлөгөө зохиох болсон. Солонгосын засгийн газраас нийтэд зориулан онлайн хэлбэрээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг болсон байна.

Сингапур⁹

Боловсрол ба ажил мэргэжлийн боловсрол (БАМБ) нь суралцагчдад сургуулиас дараагийн түвшний сургалт болон ажилд амжилттай шилжихэд туслах зорилгоор тэдний зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, чадвар, үнэт зүйлийг суралцахад чиглэсэн байна. Ингэснээр суралцагчид өөрсдийн ажил мэргэжлийн замнал болон насан туршийн боловсролоо удирдан жолоодох боломжтой болно. Энэ боловсролоор дамжуулан 21-р зууны суралцагчдын нийгмийн, сэтгэл санааны чадамжууд болон идэвх санаачилгатай, дасан зохицох болон уян хатан чанаруудыг хөгжүүлнэ. БАМБ нь дараах зорилготой:

1. Суралцагчдын өөрийгөө ухамсарлах, өөрийгөө удирдах, болон тасралтгүй суралцахтай холбоотой амьдралын чадваруудыг дэмжих (Чадварууд)
2. Суралцагчдад бодит мэдээллийг хүргэх замаар илүү сайн боловсролын, ажил мэргэжлийн боломж байгаа эсэхийг нээж илрүүлэх боломж олгох (Мэдлэг)
3. Ажил мэргэжлийн үнэт зүйлд анхааралтай, талархалтай хандах, ингэснээр нийгэмд сайн сайхан амьдрахад энэ нь ямар хувь нэмэр оруулах (Сэтгэлгээ)
4. Эцэг эхтэйгээ харилцах болон ажил мэргэжлийн нөлөөллийг ойлгож мэдэхэд хэрэг болох чадвар эзэмших (Хамтран ажиллах)

⁹ <https://www.google.com/search?q=ecd+curriculum+singapore>

Боловсрол ба ажил мэргэжлийн боловсрол (БАМБ) олгох үйлчилгээ нь сургалтын түвшин бүрд үзүүлэх үйлчилгээний агуулга, чиглэлийн хувьд ялгаатай байна.

Бага сургууль: Ухамсарлах

Зорилго: Суралцагчдад одоо байгаа болон шинээр бий болж байгаа олон төрлийн ажил мэргэжлийг танилцуулах замаар дараах ойлголт ухамсрыг бага сургуулийн суралцагчдад бий болгоход чиглэсэн:

- Сонирхол, чадвар болон хүсэл эрмэлзэл
- Өөрийгөө бусадтай болон ажил мэргэжилтэй холбох
- Ажил мэргэжлийг дүрд тоглох тоглоомын аргаар мэдэх

2012 оноос хойш 3-6 дугаар ангийн боловсрол ба мэргэжлийн боловсрол хичээлүүд нь багшийн чиг баримжааны сургалтын нэг хэсэг болсон. Эдгээр хичээлүүд нь дараах дизайнтай байдаг:

- Суралцагчдад өөрсдийнх нь давуу болон сул талыг ухамсарлуулах
- Тэдэнд боловсролын чиглэл, зам мөр, дунд сургуулийн сонголт хийхэд туслах
- Илүү олон ажил мэргэжлийн боломжийг нээхэд туслах, ирээдүйн талаар хүсэл мөрөөдлөө тэтгэн хөгжүүлэхэд дэмжих

Дунд сургууль: Ажил мэргэжлийг нээж илрүүлэх

Зорилго: Суралцагчид өөрсдийгөө танин мэдэхэд чиглэсэн ойлголтуудын талаар оо мэдлэгээ гүнзгийрүүлэх сургуулийн боловсролыг өөр боловсролын болон ажил мэргэжлийн боломжуудтай холбох:

- Ажил мэргэжлийн ертөнцийн талаар олж мэдэх
- Ажил мэргэжилтэй холбоотой сургалтын талаар ойлголттой болох
- Чадвар, сонирхол болон үнэт зүйлийн талаар ойлголт, ухамсраа хөгжүүлэх

Ахлах болон ахлах сургуулийн дараах сургалт: Ажил мэргэжлийн төлөвлөлт

Зорилго: Суралцагчид боловсрол, ажил мэргэжлийн ухаалаг сонголт хийхэд төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулах чадвартай болох:

- Өөрт тохирсон ажил мэргэжлийн концепцийг тодорхойлох,
- Мэдээлэл цуглуулах чадварыг хөгжүүлэх
- Асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх

Ахлах болон их сургуулийн бэлтгэл сургуулиудад орж буй боловсрол ба ажил мэргэжлийн боловсрол хичээл:

Энэ хичээл нь сургуульд ордог зан төлөв ба иргэний боловсрол хичээлийн хүрээнд модуль хэлбэрээр зохион байгуулагддаг. Залгамж шинж чанартай буюу хичээл бүр нь өмнөх хичээл дээр судалсан агуулга дээр үндэслэдэг.

Хүснэгт 8. Агуулгын 4 ай

Ай	Агуулга
Хэн гэдгээ таньж мэдэх	• Өөрийн сонирхол, үр чадвар, хүсэл тэмүүлээ тасралтгүй хөгжүүлэх, хэрэглэх • Ирээдүйд эзэмших мэргэжлээрээ дамжуулан нийгэмдээ бодитой хувь нэмэр оруулах
Итгэлтэйгээр өөрийн чиглэл, зам мөрөө удирдан жолоодох	• Ажлын ертөнц, боловсрол болон ажил мэргэжлийн чиглэлийн талаар илүү ихийг мэдэх • Ажил мэргэжлийн чиглэл бүр тасралтгүй сурах, дэвжих боломжуудыг олж харах
Оновчтой шийдвэр гаргах, түүндээ хариуцлагатай байх	• Өөрийн боловсрол, ажил мэргэжлийн төлөвлөлтөө ухаалгаар хийх • Хувийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд үр дүнтэй алхмуудыг төлөвлөж хийх
Тасралтгүй сурах, уян хатан байх	• 21 зууны чадамж, үнэт зүйлээ хөгжүүлэх • Дасан зохицох, уян хатан ажлын чадваруудыг хөгжүүлэх

Боловсрол, ажил мэргэжлийн боловсролын сургалтыг хэрэгжүүлдэг арга замууд


Сургуулиуд өөр өөр арга замаар энэ сургалтыг хэрэгжүүлдэг. Дараах хүснэгтэд энэ аргуудын зураглалыг үзүүлэв.

Хүснэгт 9. Сургалтын арга замууд

Зөвлөх	Хөтөлбөр	Чадамж төлөвшүүлэх	Түншлэл
Боловсрол ба ажил мэргэжлийн боловсролын зөвлөгч	Хөтөлбөрийн баримт бичиг	Боловсрол ба ажил мэргэжлийн зөвлөгчийн удирдлага дор төлөвшүүлэх ажиллагаа	Боловсрол ба ажил мэргэжлийн зөвлөгчийн зохицуулалтаар

Бага ангид - 3-6 дугаар ангиудад сургалтын багц материал ашиглаж заадаг. Энэ материал нь тухайн хичээлийн жилийн өмнөх жилийн 3 сар гэхэд боловсруулагдаж бэлэн болсон байдаг.

Дунд ангид - Зан төлөв ба иргэний боловсрол хичээлийн бүрэлдэхүүнд багтдаг ба дор хаяж 4 цагийн туршлага судлах хичээл байдаг.



АМЧБО үйлчилгээний насанд хүрэгчдэд ХЗЗ-д нэвтрэх, мэдээлэл зөвлөгөө авах, сургалтад хамрагдах боломжийг тасралтгүй олгож байх бодлого үйл ажиллагааны чиглэлийн гол үндэс гэдгийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 2020 онд гаргасан судалгаандаа дурдсан байна. Ялангуяа Ковидын нөхцөл байдлаас үүдэн олонх насанд хүрэгчид ажлаа алдан, ажилгүйдэлд өртөж шинэ боломж, ажил мэргэжил эзэмших, ХЗЗ-ийн өөрчлөлтөд дасан зохицох нөхцөл боломжийг хайж байгаа нь АМЧБОУ-ний ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна гэжээ. Гэхдээ хүүхэд залуучуудад үзүүлж байгаа үйлчилгээ болон болон насан хүрэгчдэд

олгож байгаа ажил мэргэжлийн чиг баримжааны үйлчилгээний бодлого болон хэрэгжилтийн түвшинд доогуур байна. Иймээс насанд хүрэгчдэд чиглэсэн АМЧБОУ-ний систем, хамрах хүрээ, хүртээмж, чанар, үр өгөөж, засаглал, санхүүжилтийн асуудлыг тусгайлан судалж зөвлөмж дүгнэлт гаргасан байна.

Европын холбооны орнуудын хүрээнд бий болгосон карьер үр чадвар гэсэн платформ нь нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зорилготой сургалт, үйлчилгээ, зуучлалын нэгдсэн талбар.

project@career-skills.eu

[Home](#) [Project](#) [Partners](#) **[Platform](#)** [News](#)  [Catalogue](#) [MOOC](#) [Map](#) [Network](#) [English](#) 

Platform

The Career Skills Platform aims at becoming the European one-stop-shop for citizens, career guidance providers and experts in the area of career skills development, which will contain:

- A comprehensive framework and Career Skills Catalogue of 12 most essential competencies, identified in many prestigious global and EU studies as crucial and most demanded in the following decade across Europe and beyond. The Catalogue will explain each skill and demonstrate the different levels of proficiency in a simple matrix, similar to the one of the European languages.
- Additionally, users will be able to identify their career skills level and further needs for improvement, using the career skills assessment tool.
- Further, the Career Skills MOOC (massive open online course) will help learners from different ages, backgrounds and societies upgrade their career skills in the 12 areas, described in the Career Skills Catalogue.
- The Career Service Map will be a free online register of career services across Europe, which will link providers and individual who look for information, guidance and support.
- The Career Service Network will be an ecosystem of career guidance professionals, policy actors and users across Europe who will benefit from the shared resources, information and data within the platform.



Career Skills Platform



Local Employment Services



What we offer:

- A free and confidential service
- One to one employment guidance
- Development of a tailored CV
- Access to a Jobs Club
- Career path planning
- Access to training courses

You can use the service if you are:

- Unemployed
- Looking for work
- Living in a neighbourhood where we work

FIND OUT MORE!

Local Employment Service

- Greendale Road, Kilbarrack (01) 832 0995
- Bunratty Drive, Coolock (01) 848 5630
- Email: LES@nspartnership.ie
- www.northsidepartnership.ie/employment

Northside Partnership

NS_Partnership

Northside Partnership

Northside Partnership


www.northsidepartnership.ie



An Roinn Coimhíre Sóisialaí
Department of Social Protection



Энэтхэгт АМЧБОУ үзүүлж буй загвар манай улсынхтай төстэй орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хариуцан хэрэгжүүлдэг байна. Үйлчилгээний загвар зураглалаас харахад нэлээд цогц хэлбэрээр үзүүлж байгаа нь сайн туршлага болохоор харагдаж байна.



ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД АМЧБО ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС

Монгол улсад Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээний тогтолцооны эх суурь тавигдаж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төслийн болон төрийн бус байгууллагууд тодорхой хэмжээгээр бий болж, улмаар тэд төрөл бүрийн арга хэмжээ, үйл ажиллагааг боловсролын болон хөдөлмөрийн салбарт хэрэгжүүлж байна. Гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн санхүүжилт, дэмжлэгтэйгээр судлаачид, эрдэмтэн багш нар сургалт арга зүйн гарын авлага, зөвлөмжийг боловсруулж, түгээх болсон байна.

Мянганы Сорилын Сангийн МБС төсөл

Ажил мэргэжлийн чиг баримжааг Монгол улсад хөгжүүлэх, залуучуудад хүргэх эхлэлийг Мянганы Сорилын Сангийн МБС төсөл тавьсан. Энэ чиглэлээр мэргэшсэн анхны 47 зөвлөхүүд бэлтгэгдсэн байсан.



“Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт” төсөл

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох /АМЧБО/ үйл ажиллагааг системтэй болгож мэргэжлийн түвшинд хүргэх чиглэлээр ШХУ болон ХБНГУ-ын санхүүжилтээр ГОУХАН-ийн төсөл 2014-2018 хооронд дэмжин ажилласан. Үүний үр дүнд бэлтгэгдсэн зөвлөхүүд нь бүх хөдөлмөрийн хэлтсүүдэд, 10 гаруй МСҮТ, коллежид ажиллаж ажилгүй иргэд, залуучуудад ажил мэргэжлээ тодорхойлох, ажлын байраа олох, карьераа дээшлүүлэх чиглэлээр зөвлөгөө өгч ажиллаж байгаа. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ нь хувь хүний ажил амьдралын аль ч үед, нас харгалзахгүй сурч боловсрох, мэргэжил дээшлүүлэх, ажил мэргэжлийн сонголт менежмент хийхэд нь туслалцаа үзүүлэх, чиглүүлэх, хөдөлмөр эрхлэх үр чадварыг тасралтгүй хөгжүүлэх насан туршийн боловсролын нэг бүрэлдэхүүн хэсэг юм.



Улсын хэмжээнд жишиг болох уг төвийг Герман, Швейцарь, Австрали улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Хөдөлмөрийн яам болон Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг” хамтран хэрэгжүүлж буй “Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн дэмжлэгтэйгээр байгуулсан. Хүүхэд залууст мэргэжлээ зөв сонгох, ажилгүй иргэдэд ажил хайхад туслэх зорилготой “Ажил, мэргэжлийн мэдээллийн төв” тухайн үеийн Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн ордонд үйл

ажиллагаагаа албан ёсоор эхлүүлсэн уг төв ажил хайж буй иргэдээс гадна эзэмших мэргэжлийнхээ талаар тодорхой ойлголт авахыг хүсэж байгаа хүүхэд, залуучууд үйлчлүүлэх боломжтой. Тэд ажил мэргэжлийн талаарх ерөнхий ойлголттой танилцаж, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө авах, цахим хэлбэрээр чадамжийн сорил бөглөж, өөрийн үр чадварын түвшин тогтоох боломжтойгоос гадна, өөрт хэрэгцээтэй мэдээллийг үнэ төлбөргүйгээр хэвлэн авч, хувиалан олшруулах бүрэн бололцоог бүрдүүлсэн.

Үүний зэрэгцээ хөдөлмөрийн салбарын мэргэжилтнүүд мэдээлэл, сургалт, уулзалт болон хэлэлцүүлэг, хөдөлмөрийн яармаг, аялал зэрэг олон талт үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах чиг үүрэгтэй. Монгол Улсад хэрэгжүүлж буй “Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн хүрээнд Ажил мэргэжлийн мэдээллийн 20 төв байгуулсны найм нь орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсүүдийн дэргэд, бусад нь төсөлд хамрагдаж буй мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг түшиглэн үйл ажиллагаа явуулж байгаа. ХЭҮСМУТ-ийн дэргэд үүд хаалгаа нээж буй шинэ төв нь өөрийн үйл ажиллагаагаараа Монгол Улсдаа жишиг загвар болж, цаашид үйлчилгээгээ улам чанаржуулан, цар хүрээгээ тэлснээр олон мянган залуус, ажилгүй иргэдэд мэргэжлийн өндөр түвшний зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.

Ажил мэргэжлийн мэдээллийн жишиг төвийг байгуулснаар мэргэжлийн мэдээллийн нэгдсэн санг бий болгож, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг цахим хэлбэрээр иргэдэд хүргэх, мэргэжлийн мэдээллийн баазуудыг макро эдийн засгийн түвшинд болон ажил мэргэжлийн салбараар, орон нутгийн түвшинд боловсруулж, хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн санд оруулж, ажил, мэргэжлийн нэгдсэн сүлжээг улс орон даяар холбох боломж бүрдэх юм байна.




Төслийн бас нэгэн бүрэлдэхүүн хэсэг – ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээний хүрээнд анхны магистрын зэрэг бүхий ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөхүүдийг бэлтгэх хөтөлбөрийг МУИС дээр

хэрэгжүүлж, суурийг нь тавьсан. Үүнээс гадна хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй байгаа мэргэжлүүдийг сурталчлахын тулд Монгол Улсад анх удаа магистрын зэрэгтэй “Ажил мэргэжлийн зөвлөх”-үүдийг Монгол Улсын Их Сургуулийн “Ажил мэргэжил судлал” хөтөлбөр бэлтгэлээ. 2019 оны нэгдүгээр сарын 22-нд тус хөтөлбөрийн анхны төгсөлтийн үйл ажиллагаа болж, магистрын зэрэгтэй 26 ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөхүүд төрөн гарч байна. “Ажил мэргэжил судлал” магистрын хөтөлбөрийг боловсруулахад Герман Улсын Холбооны Хөдөлмөрийн Агентлагийн Их Сургуулийн эрдэмтэн багш нар оролцсон. МУИС дээр Ажил мэргэжлийн судлалын Магистрын хөтөлбөр бий болсны үр дүнд энэ салбарыг академик түвшинд хөгжүүлэх гарц нь нээгдсэн.



Манай улсад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, газруудаас ажлын байрны зуучлал, чиг баримжаа олгох сургалт, зөвлөгөө зохион байгуулдаг. Ажил, мэргэжлийн чиг баримжааны зөвлөх мэргэжилтнүүдийг богино хугацааны сургалтаар мэргэшүүлэхийн зэрэгцээ 2017 оноос эхлэн МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль “Ажил мэргэжил судлал” магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэргэжлийн ажил мэргэжлийн зөвлөх мэргэжилтнүүдийг бэлтгэж эхэлжээ. Тус хөтөлбөрөөр бэлтгэгдсэн анхны магистрын зэрэгтэй ажил мэргэжлийн зөвлөх мэргэжилтнүүд 2019 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр магистрын дипломоо гардан авах юм. Тус магистрын хөтөлбөрийг ХНХЯ-ны захиалгаар Германы хамтын ажиллагааны нийгэмлэг(GIZ)-ийн “Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт” төсөл Герман, Швейцар, Австрали улсын засгийн газрын санхүүжилтээр дэмжин хэрэгжүүлжээ. Мөн мэргэжлийн магистрын хөтөлбөрийн сургалтад шаардлагатай онол аргазүйн ном, нэр томьёоны тайлбар толь боловсруулах болон багш нарыг чадавхжуулах чиглэлээр Азийн хөгжлийн банкны Дээд боловсролын шинэчлэлийн төслөөс дэмжлэг үзүүлжээ.

“Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжааны цахим хөтөч веб сайт **МЭРГЭЖИЛ.МН** болон гар утасны аппликейшнийг олон нийтэд бэлтгэн хүргэсэн.



Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчдад сонгогдсон 60 мэргэжлийн талаар тодорхой ойлголт өгөх, эдгээр мэргэжлийг хаана, ямар сургуульд суралцан эзэмших боломжтой, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын сургалт явуулдаг мэргэжлийн чиглэл, хөдөлмөрийн зах зээл, эрэлттэй ажил мэргэжлийн

талаар мэдээллийг зорилтот бүлэгт зориулан ойлгомжтой зураглал хэлбэрээр мэдээлэл тухайн үеийн Хөдөлмөрийн яам, Хөдөлмөр эрхлэлт, үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төв, Боловсролын яам, Үндэсний статистикийн газар, төсөл хөтөлбөрүүд, сургалтын байгууллагуудтай холбогдон бодит албан ёсны эх үүсвэрээс тухайн мэргэжил тус бүрийн тодорхойлолт, гүйцэтгэх үүрэг, цалин, цаашид суралцах боломж, сургалтын хөтөлбөр гэсэн мэдээллийг нарийвчлан боловсруулан сайтад оруулсан.

Гар утасны аппликейшн боловсруулах ажлын чиглэлээр:

Гар утасны аппликейшн нь ухаалаг гар утасны үйлдлийн систем дээр ажиллах боломжтой байх хэлбэрээр цахим хуудасны зарим мэдээллийг хялбаршуулсан хэлбэрээр оруулсан.

СД боловсруулах чиглэлээр:

Цахим хуудасны мэдээллийг интернэтгүй орчинд хэрэглэх зорилгоор нийт 1000 ширхгийг бэлтгэсэн холбогдох талуудад хүлээлгэн өгсөн болно.

Агуулга



Цэс доторх мэдээллийн агуулга:

Ерөнхий мэдээлэл: Хууль, эрх зүй, Элсэлтэд тавигдах шаардлага, Ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт, Мэргэшлийн түвшний тогтолцоо, Хөдөлмөрийн зах зээл, Цалин, Төслүүдийн мэдээлэл, Статистик мэдээлэл, Ур чадварын тэмцээн, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн лавлах

Салбар: Салбар, Дэд салбар, Мэргэжил, Индекс, Түвшин

Мэргэжил: Нэр, Мэргэжлийн индекс, Үндсэн үүрэг чиглэл, Сургалтын хөтөлбөр, Ирээдүйд ахих дэвших боломж

Сургалтын байгууллагын мэдээлэл: Нэр, Байршил, Байгуулагдсан он, Өмчийн хэлбэр, Холбоо барих, Цахим хуудас, Нийт суралцагсдын тоо /үүнээс эмэгтэй/, Багшийн тоо, Дотуур байртай эсэх, Хичээлийн жилийн хугацаа

Мэргэжил.mn сайтыг өргөжүүлэн МБС-ын Үнэлгээ, мэдээлэл, аргазүйн төвийн үндсэн вэб сайт болгон өргөжүүлж АМЧБ-ны талаарх мэдээллийг нэг талбар болгон өөрчлөн тогтвортой байдлыг ханган ажиллаж байгаа ч анх хөгжүүлсэн байдлаар шинэчлэл хийгээгүй хэвээр байна.

Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төсөл

Монгол улсын засгийн газар Азийн хөгжлийн банкны Тусгай сангийн зээлээр Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төслийн хүрээнд ЕБС-д АМЧБО зөвлөх үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг МУБИС-ийн төслийн нэгж хэрэгжүүлж байна. 2018-2019 оны хичээлийн жилээс АМЧБО сургалтыг сургуулийн мэдлийн 35 цагт багтаан, хичээлийн албан ёсны хуваарьт оруулж, нийгмийн ажилтан болон анги удирдсан багш нар сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж, удирдамж, арга зүйн зөвлөмж, чиглэл боловсруулжээ.

Энэхүү гарын авлагыг МБСБ-д АМЧБО үйлчилгээг хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан бэлдсэн бөгөөд МБСБ-ын суралцагчдад нэгэнт сонгосон мэргэжлийнх нь хүрээнд хувь хүний хөгжил, карьер хөгжлийн төлөвлөгөө, ажлын байранд бэлдэх зуучлах үйлчилгээг үзүүлэхэд нь дэмжлэг болох зорилгоор суралцагчдад ангийн ялгавартайгаар тухайн агуулгын хүрээнд үзүүлэх үйлчилгээний чиглэлээр ерөнхий удирдамжийг тусгасан. Сургууль бүр өөрийн онцлогт тохируулан сургалтын хэрэглэгдэхүүн болгож гарын авлагыг хэрэглэх боломжтой.




Ажил мэргэжлийн чиг баримжаа гэж юу вэ? Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн ажил мэргэжлийн чиг баримжаа нь суралцагчид болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад ахлах ангид судлах хичээл, хөтөлбөрөө сонгох, 12 дугаар анги төгссөний дараа суралцах мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон их, дээд сургууль, мэргэжлийн хөтөлбөрөө сонгох, хөдөлмөрийн зах зээлд ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ухаалаг, бодитой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлдэг сургуулийн болон сургуулиас гадуурх үйл ажиллагаа болгосон.


Яагаад ажил мэргэжлийн чиг баримжааг ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх шаардлагатай вэ? i) Бүх төрлийн, бүх түвшний сургалт эцсийн дүндээ хөдөлмөрийн зах

зээлтэй холбогддог буюу ГИНЖИН НӨЛӨӨЛӨЛ Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн хичээл сонголт, мэргэжлийн боловсрол, сургалт болон их дээд сургуулийн мэргэжлийн хөтөлбөрийн сонголт нь бие биедээ гинжин хэлбэрээр нөлөөлдөг бөгөөд эцсийн дүндээ хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой дараах чадвар зайлшгүй чухал. Юуны өмнө ажил мэргэжлийн оновчтой сонголт, ухаалаг шийдвэр гаргахын тулд суралцагчид ажил мэргэжил болон сургалтын талаарх хөндлөнгийн мэдээллийг тайлбарлаж, өөрийн мэддэг мэдээлэлтэй (өөрийнхөө талаарх мэдлэг, итгэл үнэмшил) уялдуулан хэрэглэж чаддаг байх хэрэгтэй. Орчин нөхцөл: Нийгэм-эдийн засаг, газарзүйн хүчин зүйлийн нөлөөлөл Ажил мэргэжлийн шийдвэр гаргахад хөндлөнгийн хүчин зүйлийг заавал харгалзах шаардлагатай. Гэр бүлийн нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, эцэг эхийн хүлээлт, эцэг эхтэйгээ харилцах харилцаа, гэр бүлийн уламжлал, газарзүйн байршил зэрэг нь суралцагчийн шийдвэрт нөлөөлдөг.



Төслийн хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох www.myfuture.mn портал сайтыг хөгжүүлсэн байна.





Суралцагчид болон эцэг эх, асран хамгаалагчдад зориулж өөрийн сонирхол, давуу талаа таньж мэдэх, чадвар, үнэт зүйлээ тодорхойлох, ахлах ангид судлах хичээл, хөтөлбөрөө сонгох, 12 дугаар анги төгссөний дараа суралцах их, дээд сургууль, мэргэжлийн хөтөлбөрөө сонгох, хөдөлмөрийн зах зээлд ажил хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ухаалаг, бодитой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох портал сайтыг ажиллуулж байна.

Суралцагчдад зориулж цаасан хэлбэрээс www.myfuture.mn цахим хэлбэрт шилжүүлэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгож байна.

Хэрэглэгч www.myfuture.mn веб сайтаас ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа, түүний талаарх мэдээ мэдээлэл авахдаа ESIS системийн бүртгэлээр, сургууль болон багш

өөрийн эрхээр нэвтрэн орох боломжтой.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох портал сайтыг ашигласнаар:


📌 **СУРАГЧ** - Өөрийн онцлогт тохирсон ирээдүйн ажил мэргэжлээ сонгох арга замыг танин мэдэх, түүнийг эзэмших хүртэлх үйл явцыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ажил мэргэжилтэй холбоотой бүхий л үйл ажиллагаа, зөвлөгөө мэдээллийг авна.

📌 **БАГШ** - Сурагчдыг системд хамруулснаар ажил мэргэжлийг таниулах, урт хугацааны шийдвэр гаргахад туслан түүний дагуу төлөвлөлт хийж, чадамжийг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ системийн ашиглалтад хяналт тавих, удирдан чиглүүлснээр ирээдүйн сайн боловсон хүчинг бэлтгэх болно.

📌 **ЭЦЭГ ЭХ** - Суралцагчдыг урт хугацааны ажил мэргэжлийн шийдвэрээ ухаалгаар гаргах, түүнийг үр дүнтэй төлөвлөдөг болгохын тулд эцэг эхийн оролцооноос хамааран хүүхдэдээ

ажил мэргэжлийн төлөвлөлт хийхэд нь зөвлөж хүүхдийн сонирхлын дагуу хөгжүүлэх боломжтой болно.

 СУРГУУЛЬ - Удирдлага, бодлого тодорхойлогчдод мэдээллээр ханган, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх өөрийн сургуулийн сурагчдын мэдээллийн санг бүрдүүлнэ.



Мөн "Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төсөл"-ийн хүрээнд "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төв"-ийг Арвайхээр сумын ЗДТГ-ын дэргэд нээжээ.

ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчид, эцэг эх, ажил идэвхтэй хайж буй иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, зөвлөгөөг тус төвөөр дамжуулан хүргэх бөгөөд сургалтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр танхимыг тохижуулжээ. Нэг удаагийн сургалтаар 15-20 хүнийг хүлээн авах бөгөөд Арвайхээр сумын "Насан туршийн боловсролын төв"-ийн мэргэжлийн багш нар сургалт, зөвлөгөө өгөх аж. "Ажил хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэд олон байдаг ч тэр бүр хүрч үйлчилж чаддаггүй. Багийн ажлын албаар дамжуулж мэдээлэл, зөвлөгөө хүргэдэг байсан бол ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төвийг байгуулснаар иргэд, дунд сургуулийн сурагчид хүссэн цагтаа ирээд мэдээлэл, зөвлөгөө авах боломж бүрджээ.

Хан-уул дүүргийн Албан бус-Насан туршийн боловсролын төвд БШУЯ, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр "Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх" төслийн хүрээнд Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхимын тоног төхөөрөмжийг нийлүүлжээ. Энэхүү танхимаар ерөнхий боловсролын ахлах, дунд ангийн сурагчид болон иргэд үйлчлүүлж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр сургалт, зөвлөгөө авах юм.Цаашид манай төв нь энэ чиглэлээр МСҮТ, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн багш, суралцагч, иргэдтэй хамтран ажиллах боломжтой болжээ.

БШУ-ны сайдын 2020 оны 200 тоот тушаалаар аймгуудад ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхим байгуулахаар шийдвэрлэсэн. Танхимын тохижилтын ажлыг түс төслөөс санхүүжүүлжээ. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхим нь цаашид аймгийн бүх ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагчдад ирээдүйн мэргэжлээ зөв сонгох, суралцах чиглэлээ тодорхойлоход нь дэмжлэг үзүүлж, хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч, багш нарт мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллах ажээ.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдлэг, чадвар, холбогдох үйл ажиллагаа

МЭДЛЭГ, ЧАДВАР	СУРГУУЛИЙН ОРЧИНД	СУРГУУЛИАС ГАДУУР
1. Өөрийн чадвар болон ажил мэргэжлийн сонирхлын талаарх мэдлэг	i. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран "Суралцагчийн гарын авлага" ашиглан зохион байгуулах ii. Сурлагын амжилт iii. Сургуулийн клуб олон сургалтыг дэмжих үйл ажиллагааны оролцох iv. Нийгмийн ажилтан ажил мэргэжлийн чиглэлээр ганцаарчилсан зөвлөгөө өгөх v. Ажил мэргэжлийн сорил	• Цагийн ажил • Сайн дурын үйл ажиллагаа • Ажлын туршлага хуримтлуулах үйл ажиллагаа • Гэр бүлийн үүрэг, оролцоо • Найз нөхдийн үүрэг, оролцоо • Чөлөөт цагаараа хийх үйл ажиллагаа • Хөгжим, спорт, бүжиг, урлагийн дугуйлан, секц
2. Ажил мэргэжил, ажлын өртөнц, ажилд тавигддаг хувь хүний болон мэргэжлийн шаардлага, ажил мэргэжил эзэмших олон янзын сургалтын замнал болон ажил хайх тухай мэдлэг	i. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран "Суралцагчийн гарын авлага" ашиглан зохион байгуулах ii. Ажил мэргэжилтэй холбоотой ном гарын авлага iii. Ажил мэргэжилтэй холбоотой вэбсайт iv. Эцэг эх, төгсөгч, ажил олгогч, Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн, мэргэжлийн холбоодын төлөөлөл илтгэл тавих, ярилцлага хийх v. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын "Ажил олгогчдын шаардлага"-ын судалгаа	• Ажлын туршлага хуримтлуулах • Цагийн ажил • Гэр бүлийн үүрэг • Орон нутгийн эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтэд хувь нэмэр оруулах • Ажлын байранд зочлох • Ажил мэргэжлийн яармаг, үзэсгэлэн • Хэвлэл мэдээллийн хэрэгсэл • Вэбсайт
3. Төрийн болон хувийн их, дээд сургууль, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, сургууль, өдрийн, эчнээ, оройн, зайн болон Цахим орчны сургалт сургалтын төрлийн талаарх мэдээлэл. Энэ мэдээлэл нь хөтөлбөрийн зорилго, зорилт, тухайн хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэргэжил, сургалтын хугацаа, зардал болон хөтөлбөрөө дүүргээд ажил хөдөлмөр эрхлэх боломжийн талаар агуулгатай байна.	i. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран "Суралцагчийн гарын авлага" ашиглан зохион байгуулах ii. Ажил мэргэжилтэй холбоотой ном, гарын авлага iii. Мэргэжлийн боловсрол, сургалт, их, дээд сургууль, зайны болон цахим сургалтын тухай вэбсайтууд (www.mergejl.mn, www.nim.edu.mn, www.msue.edu.mn гэх мэт) iv. Төгсөгч, их дээд сургуулийн оюутан, эцэг эх, сургалтын байгууллагын төлөөлөл илтгэл тавих, ярилцлага хийх (мэргэжлийн боловсрол, сургалт, их, дээд сургууль, зайны болон цахим сургалтын) v. Мэргэжлийн боловсрол, сургалт, их, дээд сургууль, зайны болон цахим сургалтын элсэлтийн шаардлагын тухай мэдээлэл бүхий гарын авлага, брошур vi. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн судалгааны институтын "Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага"-ын судалгаа	• Вэбсайтаас шаардлагатай мэдээлэл цуглуулах • Сургалтын байгууллагуудын элсэлтийн талаарх мэдээлэл, гарын авлага, брошур • Сургалтын байгууллагуудад зочлох • Боловсролын яармаг, үзэсгэлэн • Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
4. Ажил мэргэжлийн төлөөлөлт хийхтэй холбоотой мэдээллийг хаанаас яаж цуглуулах болон мэдээллийн эх сурвалжийг үнэлэх	i. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран "Суралцагчийн гарын авлага" ашиглан зохион байгуулах ii. Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх	• Гэр бүл найз нөхөдтэйгээ зөвлөлдөх, • Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авах

5.Ажил мэргэжил, сургалтын талаарх хөндлөнгийн мэдээлэл болон өөрийн чадвар, сонирхлын талаарх мэдээллийг ашиглан төлөвлөлтийг хэд хэдэн хувилбартай хийх	i. 10-12 дугаар ангид сургуулийн нийгмийн ажилтан болон анги удирдсан багш хамтран тодорхой зохион байгуулалттай үйл ажиллагааг "Суралцагчийн гарын авлага" ашиглан зохион байгуулах	- Гэр бүл найз нөхөдтэйгээ зөвлөлдөх, - Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнээс зөвлөгөө авах
6.Ажилгүйдэлд бэлтгэлтэй байх	i. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох танхимын үйл ажиллагаа ангийн багш болон нийгмийн ажилтан хамтран "Суралцагчийн гарын авлага" ашиглан зохион байгуулах ii. Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх	- Гэр бүл найз нөхдийн туршлага, ажиглалт - Хөдөлмөрийн хэлтсийн холбогдох мэргэжилтнийн зөвлөгөө
7.Ажил хөдөлмөр эрхлэх бэлтгэл болох ажил хайх чадвар. Энд: -Өргөдөл бичих -Товч намтар (CV) боловсруулах -Ажлын ярилцлага бэлтгэх -Ажил хайхад өөрийн мэдэх сүлжээг ашиглах -Ажилд зуучлах байгууллагууд -Орон нутгийн хөдөлмөрийн хэлтэс	i. Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн ажилтан уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх ii. Төгсөгч, эцэг эх болон ажил олгогчид уулзалт, ярилцлага хийх iii. Ротари клуб, Худалдаа аж үйлдвэрийн тэнхим, Төрийн бус байгууллагатай хамтран уулзалт, ярилцлага хийх	Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтэст зочлох
8. Ажлын байранд шаардлагатай мэдлэг, чадвар: -Хөдөлмөрийн хууль, гэрээний талаар мэдэх (хүйсийн асуудлыг мөн авч үзэх) -Ажлын байрны зан үйл болон бусад шаардлага -Хөдөлмөрийн зах зээлд хэрхэн хөдөлгөөнтэй, идэвхтэй байх	i. Орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсийн ажилтан уулзалт, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх	
9.Хувиараа хөдөлмөр болон аж ахуй эрхлэх	i. Ротари клуб эсвэл Худалдаа аж үйлдвэрийн тэнхимтэй хамтран хувиараа аж ахуй, хөдөлмөр эрхлэгчийг урьж уулзалт, ярилцлага хийх ii. Суралцагчдын дунд "мини-аж ахуй эсвэл компани" үүсгэх, удирдахад дэмжлэг үзүүлэх клубууд ажиллуулах	

АХБ-ны Хөдөлмөр эрхлэх үр чадварыг дээшлүүлэх төслийн ЧССҮ өргөтгөл гэрээний зөвлөх үйлчилгээний хүрээнд МБСБ-ын түвшинд Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ хэрхэн зохион байгуулагдаж байгаа, цаашид хэрхэн сайжруулах талаар нөхцөл байдлын судалгааг 2017-2018 оны хичээлийн жилд зохион байгуулсан. Судалгааны үр дүнгээс харахад МБСБ-д элсэн суралцагчид мэргэжлээ зөв сонгоогүйгээс эзэмшсэн мэргэжлээрээ ажиллахгүй, өөр мэргэжлээр Их дээд сургуульд суралцах, ажлын байр байгаа хэдий ч ажиллах сонирхолгүй байдаг нь түгээмэл ажиглагдсан. Түүнчлэн МСҮТ, ПК-ийн түвшинд ажил мэргэжлийн чиг баримжааны үйлчилгээний суурь тогтолцоог боловсронгуй, системтэй болгох шаардлага байгааг судалгааны үр дүн харуулсан. Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хөгжилд гарсан нэгээхэн чухал амжилт, дэвшил бол төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байранд зуучлах үйлчилгээг бий болгосон явдал юм.

КАРЬЕР ХӨГЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Төгсөгчдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх олон арга зам, хэлбэрийн нэгээхэн чухал хэсэг, түшиц бааз суурь нь ажил олгогч буюу нийгмийн түншлэлд суурилсан хамтын ажиллагаа юм гэж томъёолсон байдаг. 2013 онд Хөдөлмөрийн яам шинээр байгуулагдаж, баримтлах бодлого чиглэлтэйгээ уялдуулан МСҮТ, ПК-ийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт хийж эхэлсэн. Их дээд сургуулиас ялгагдах, давуу тал болсон томоохон алхам нь анх удаа МСҮТ, ПК-д төгсөгчдийн зуучлал хариуцсан алба, мэргэжилтний орон тоог бий болгосон. Өнөөдөр, МСҮТ, ПК-ийн нийгмийн түншлэл

хариуцсан ажилтнууд нь нийгмийн түншлэлийн хүрээнд сургуулийнхаа суралцагчдыг үйлдвэрлэлийн орчинд дадлагажуулах, мэргэжлийн үр чадвар олгох ба төгсөнгүүт тухайн байгууллагад нь тогтвор суурьшилтай ажиллахад нь дэмжих, суралцах хугацаанд нь хөдөлмөр эрхлэх үр чадварыг олгох, зөвлөн туслах хэлбэрээр ажиллаж байна.


Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг МСҮТ, ПК-ийн нийгмийн түншлэлийн ажилтнууд ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу хариуцаж ажилладаг юм байна.

Суралцагчдын хөдөлмөр эрхлэх үр чадварыг хөгжүүлэх сургалтын арга зүйг боловсруулах, нэгдсэн стандарт, сургалтын хөтөлбөртэй болох ба цаашид албан ёсны хичээлийн хуваарьт оруулах нь оновчтой байна. Суралцагчийн долоо хоног, сар, жилийн суралцах ачаалал, нормыг тэнцвэржүүлэх үүднээс сургалтын нэгдсэн төлөвлөгөөний цагийн ачаалалд дахин судалгаа хийж өөрчлөлт оруулж болох юм.

АМЧБО үйл ажиллагааг хичээлийн жилийн туршид тасралтгүй зохион байгуулах хэрэгтэй.

Нийгмийн түншлэлийн ажилтан, ажил мэргэжлийн чиг баримжааны ажилтнуудын ашиглаж буй ихэнх гарын авлага, зөвлөмж, хэрэглэгдэхүүний агуулга нь ерөнхий боловсролын сурагчид, багш нарт зориулагдсан байгаа нь ажиглагдсан. МСҮТ, ПК-ийн суралцагчдын хувьд мэргэжлээ сонгоод суралцаж байгаа ба тэдний хувьд сонгосон мэргэжилдээ дур сонирхолтой байх, амжилттай суралцах, ажил хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг хайх арга зам, ажилд орох үйл явц, хувийн зорилгоо тодорхойлох, карьер хөгжлөө төлөвлөх зэрэг үр чадварыг олгохуйц, зорилтод бүлгийн сонирхолд нийцсэн агуулга бүхий сургалтын хөтөлбөр, зөвлөмж, арга зүйн гарын авлага хэрэглэгдэхүүн дутмаг байна. Түүнчлэн МСҮТ, ПК-ийн суралцагч, төгсөгчид, эцэг эх, багш нарт зориулсан гарын авлага хэрэглэгдэхүүн боловсруулж түгээх хэрэгцээ байна. Тэрхүү материал, хэрэглэгдэхүүн нь суралцагчдын ажил хөдөлмөрийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, хүсэл сонирхол, чадавхыг хөгжүүлэхэд чиглэсэн агуулга бүхий байх нь зүйтэй.

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ. Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулжээ.



Швейцарын Хөгжлийн Агентлагийн Баруун Бүсийн МБС- ын төсөл

ШХА-ийн Баруун Бүсийн МБС-ын төсөл 2012-2015 онд АМЧБО зөвлөх үйлчилгээний төвийг МБСБ дээр байгуулж төвийг цаашид байгуулахад дэмжлэг болох зөвлөмжийг боловсруулан гаргасан.

Улаанбаатар хотноо Баянхонгор, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай аймгийн Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ, ПКийн багш, удирдах ажилтан, Улаанбаатар хотын Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг хамтран “Ажил мэргэжлийн зөвлөхийн мэргэжлийн стандартын загвар, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээний чанарын шаардлагын каталог, ажил мэргэжлийн зөвлөхийн ёс зүйн дүрмийн загвар” боловсруулсан байна. Тус арга хэмжээний хүрээнд боловсруулсан материалыг нэгтгэн гарын авлага болгон сургуулиуд, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ажлын албан хэрэгцээнд түгээжээ.

Швейцарын Хөгжлийн Агентлагийн “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл

ХӨДӨЛМӨР, НИЙГЭМЭЙН ХАМГААЛТЫН ЛАМ

SDC Swiss Development Cooperation SDC Swiss Agency for Development and Cooperation SDC Швейцарын хөгжлийн агентлаг

GFA CONSULTING GROUP

ҮР ДҮНГИЙН ТӨВЧӨӨН

2020 оны 9 дүгээр сарын байдлаар

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Хугацаа: 2016 оны 1 дүгээр сар - 2020 оны 12 дугаар сар	Төсөв: 2,400,000 Швейцар Франк (Үе шат II) 1,650,747 Евро (Үе шат III)
--	--

НЭГ. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийг Төслийн зорилгот 8 аймаг, 2 дүүргэд 2016-2018 оны нутагд амжилттай туршин хэрэгжүүлж, улмаар төслийн нүгдэс шаардлагатай бодлогын зөвлөмж боловсруулах, модлог, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэлээр хангах замаар “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийг 2018 оны 1 дүгээр сард Хөдөлмөр нийгмийн хамгааллын Салдын ажлын Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр (ХЗҮЗ) батлуулсан. Тус хөтөлбөрийг төслийн боловсруулсан загвар снөөгө үндэслэн ороо бүх аймаг, дүүргэд хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих засаглал, удирдлагын механизмыг сайжруулахад чиглүүлэн нийгмийн түншүүдийн чадварыг бэхжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнг хэмжих үзүүлэлтүүдийг ХЗҮЗ-өөр батлаж, улмаар үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Төслөөс боловсруулан, туршин хэрэгжүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний аргачлалыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний өрөөний газрын (ХӨГҮГ) даргын 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн А/73 тоот тушаалаар баталж, улмаар загвар үйлчилгээг бүх аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хэрэгжүүлж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл,
Монгол Улс, Улаанбаатар хот
Баян-Уул дүүрэг, 14240, Их Монгол улаан гудамж, 15-р хороо, Монгол Басолдын 2-р дэвир
Утас: +976 77116171

ХОЁР. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний Загвар төвөгт нийт 16 аймаг, 5 дүүргэд байгуулж, 560 гаруй сая төгрөгийн санхүүгээр, тусгай тэмцүүлгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст (ХӨГҮГ) нэрлэгдэн өгсөн. Загвар Загвар төвөгт хөдөлмөр эрхлэлтийн дараах шинэсэг үйлчилгээг тусгай дэргэд байрлана. Үүнд: Хөдөлмөр эрхлэх үр чадварын үнэлгээ, Хөдөлмөр эрхлэх хүнийн төлөөлөгч, Үе шаттай таван модуль сургалт, Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, Залуучуудын гарааны бизнесийг дэмжих үйлчилгээ зэрэг болно. Нийт 11 аймаг, 5 дүүргийн Загвар төвөгт нийт 16,000 орчим залуучууд 9,300 амьттай хамрагдсан.

Залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн шинэсэг үйлчилгээ Гарын аялага, сургалтын багц материалыг, видео мэдээл боловсруулж, шинэсэг үйлчилгээ агуулах чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн алба, хэлтэс, хүнийн хөдөлмөрийн бүржүүдийн ажилтан, менежерүүдийн чадварыг шат дараалан бэхжүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн шинэсэг үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр 11 аймаг, 2 дүүргийн ХӨГҮГ, 2 хүнийн хөдөлмөрийн бизнес нийт 28 нэвтрүүлэг олон улсын зөвлөмж мэдээллийг тусламттай бэлтгэсэн.

Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрхлэлтийн судалгааг төслийн зорилгот 8 аймагт зохион байгуулж, судалгаа болон сургалт сэмжар хийхэд нийт 120 орчим сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үүний үр дүнд аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн эрхлэлтийг дэлгэр заслын сайбар, мэргэжлээр тодорхойлж, дүн шинжилгээ хийсэн бөгөөд эрхлэлтийн тоон ба чанарын судалгаа нийт арга зүйн чиглэлээр орон нутгийн судалгааны багийн чадварыг бэхжүүлсэн. Орон нутгийн ХЗЗ-ийн судалгааг тусгай дэргэдүүр хэрэгдэл төслийн бүс 3 аймагт тус судалгааг хийх чиглэлээр мэргэжлийн зөвлөгч ач ажиллаж байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэсэг арга, үйлчилгээг туршин хэрэгжүүлж байна. Тухайлбал, ажлын дадлага зориулсан Интерактив хөтөлбөрийг 1 аймаг, 1 дүүргэд туршин, нийт 30 ажлын олох, 42 залуус оролцсон ба 40 хуви нь тухайн байгууллагад үндсэн ажилтнаар орсон. Хөдөлмөр эрхлэлтийн шинэсэг үйлчилгээг Турчин зорилгот бүлэг буюу эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглүүлэн ажиллаж байна.

ГУРАВ. Залуучуудын гарааны бизнес

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн (ХЗГБДХ) хүрээнд төслийн 8 аймаг, 2 дүүргэд шалгарсан гарааны бизнесийн 26 багт нийт 256 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Хөтөлбөрт оролцсон багуудад гарааны бизнесийн сургалт, арга хэмжээнд хамруулж, шалгарсан багуудад хурдастуур сургалтын хөтөлбөрт хамруулж, менторын зөвлөгч өгсөн. Төслөөс дэмжлэг зэвс гарааны бизнес эрхлэгчдийн 95 хуви нь амьттай ажиллаж, 54 хуви нь хамтат, ААН-ээр бүртгүүлж, нийт 124 залуучуудыг ажлын байртай болгосон. Тус хөтөлбөр нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрийн нэг болсноор ороо ХНХ-ны удирдлага дор бүх аймаг, дүүргэд ХЗДС-гаас авч гарааны бизнесийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2019 онд үр Хөтөлбөрийн хүрээнд сөнүгдлийн дэмжлэг үзүүлж, арга хэмжээ зохион байгуулахад ХЗДС-гаас нийт 4.92 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Бизнес хөгжлийн байгууллагыг чадавхижуулах ажлын хүрээнд орон нутгийн залуучуудад бизнес хөгжлийн үйлчилгээг үр дүнтэй хурга зоригоор 102 ментор, 30 менторингийн хөтөлбөргүйг, дамгарсан тоогоор 130 сургалч багш бэлтгэсэн. Гарааны бизнесийг дэмжих чиглэлээр аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, албаны мэргэжилтнүүдийн чадварыг бэхжүүлсэн бөгөөд холбогдох Гарын аялага, зөвлөмж материалыг боловсруулсан. Түүнчлэн орон нутагт гарааны бизнесийн эсв системийг бүрдүүлэх, нэгжүүлэх зорилгоор төслийн зорилгот аймаг, дүүргүүдэд Гарааны бизнесийг дэмжих орон нутгийн ажлын хэсгүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлж, чадавхижуулсан.


Гарааны бизнесийн мэдээллийн нэгдсэн платформ: (www.startupbase.mn) гарааны бизнесийн оролцогч багуудыг нэгдсэн мэдээлэлээр хангах, хамтран ажиллах цахим орчинг бүрдүүлэх зорилгоор байгуулсан. Тус платформд гарааны бизнес эрхлэгч, ментор, хөрөнгө оруулагч, ментор болон бусад холбогдох байгууллагуудын мэдээллийг багтгасан бөгөөд платформын нэгжүүлэлтийг үргэжүүлэн хийж байна.

Швейцарын хөгжлийн агентлагийн 38,7 сая төгрөгийн санхүүжилтээр Германы GFA компани хэрэгжүүлж буй төслийн хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв” нэртэйгээр байгуулагдан 2019 оны 5-р сараас эхлэн иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Гол төлөв 15-34 насны залууст сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, бүлгийн сургалт зохион байгуулах, гарааны бизнесээ хэрхэн удирдах талаар зөвлөх, ажил олгогч байгууллагын хүний нөөцийн менежерүүдтэй хамтарч ажил хайгч иргэдийг ажлын байранд зүүчлэх, ганцаарчилсан зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээг үзүүлж байна. Ажил хийх хүсэл эрмэлзэлтэй залуус сайн дурын үндсэн дээр манай төвд ханддаг. 2019-2020 онд давхардсан тоогоор 2200 ажил хайгч иргэн хөдөлмөр эрхлэлтийн талаар чиг баримжаа, зөвлөгөөг авч, ажлын байранд зүүчилсэн. Мөн 2020 онд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах модуль сургалтыг 2-3 удаа зохион байгуулж, 35 залуу ажиллах хүчнийг

хамруулсан.

2.7 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөдөлмөр эрхлэлтийн шинэлэг үйлчилгээ, үүний дотор Ажил хайгч залуучуудын хөдөлмөр эрхлэх ур чадварт үнэлгээ хийх, Хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулах үйлчилгээг үзүүлэх үйл явцыг хөнгөвчлөх зорилгоор эдгээр үйлчилгээг цахимжуулах ажлыг төслөөс санаачлан хэрэгжүүлсэн. Ингэснээр ЗХЭҮЗТ-ийн ажилтнууд болон ажил мэргэжлийн чиг баримжааны зөвлөх мэргэжилтнүүд дээрх хоёр үйлчилгээг вэб-д суурилсан цахим хэлбэрээр, батлагдсан маягт, аргачлалын дагуу гүйцэтгэх боломжтой болсон бөгөөд ингэхдээ нэмэлт асуумж, сорилыг цахимаар шууд ашиглах боломжтой. Түүнчлэн, энэхүү вэб сайтыг ашиглан тодорхой хугацааг хамарсан тайлан мэдээ гаргах, шаардлагатай бусад статистик мэдээллийг түүвэрлэн гаргах боломж бүрдэж байна (yesdesk.mn).



Вэб сайтын хөгжүүлэлтийг S-Ray Soft компани гүйцэтгэсэн бөгөөд үүнд Баянгол дүүргийн ЗХЭҮЗТ-ийн ажилтан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээтэй холбоотой мэргэжлийн зөвлөгөө, чиглүүлгийг өгч хамтран ажилласан. Вэбсайтыг урьдчилсан байдлаар хөгжүүлж, сонгосон ЗХЭҮЗТ-үүдэд туршсаны дараа Загвар төвийн ажилтан, мэргэжилтнүүдийг хамруулсан цахим сургалт, уулзалтыг зохион байгуулж, улмаар туршилт хийсэн 7 Загвар төвийн гаргасан вэбсайтын талаарх санал зөвлөмжийн дагуу сайжруулалт, нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж байна. Вэбсайтын хөгжүүлэлтийг эцэслэсний дараа түүнийг бусад аймаг, дүүрэгт түгээн дэлгэрүүлэх ажлыг гүйцэтгэх болно.

“Ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” төсөл

2016 оноос Европын холбооны санхүүжилттэй “Ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” (SECIM) төсөл хэрэгжиж эхэлсэн ба энэхүү төслийг туршин нэвтрүүлэхээр Сэлэнгэ, Дорнод, Завхан аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрууд сонгогдсон. Төслийн хүрээнд эдгээр аймагт хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг чадавхжуулах сургалтуудыг ээлж дараатайгаар хийж буй юм. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2017 оны А/263 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад мэргэшсэн сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох арга зүйн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр аймгуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах “Ажил, мэргэжлийн чиг баримжааны зөвлөх бэлтгэх” 40 цагийн сургалтыг SECIM төслийн хүрээнд зохион байгуулсан байна.

Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл

2017-2022 онд хэрэгжиж буй энэ төсөл ажил хайгч, бичил бизнес эрхлэгчдэд ХЗЗ дэх боломжуудыг илүү хүртээмжтэй хүргэх, Ковид-19 цар тахлын үед албан бус салбарт ажиллагчдад богино хугацаанд дэмжлэг үзүүлэх зорилтой. Төслийн хүрээнд ажил мэргэжлийн төвүүдийг байгуулж АМЧБО үйлчилгээг тус төвөөр дамжуулан хэрэгжүүлэх юм.


10 аймаг, 4 дүүрэг ажил мэргэжлийн төвтэй боллоо

Үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцөлийг сайжруулж шинэлэг өнгө төрхийг бүрдүүлсэн, нэгдсэн нэг стандарт бүхий “Ажил мэргэжлийн төв” (үйлчилгээний заал, сургалтын өрөө, ганцаарчилсан зөвлөгөөний өрөө)-ийг Завхан, Увс, Ховд, Говь-Алтай, Орхон, Дундговь, Сүхбаатар, Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ аймаг, Налайх, Сонгинохайрхан, Баянгол, Багануур дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст байгууллаа.

Ингэснээр ажилд зуучлах, ажил хайгч нарт мэдээлэл, зөвлөгөө өгөх, ажлын байрны зарыг олон нийтэд түгээх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үр дүнтэй хүргэх орчин нөхцөлийг сайжруулан, үйлчилгээний шинэлэг өнгө төрхийг бүрдүүллээ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчныг бүрдүүлж, налуу зам тавих, ариун цэврийн өрөөг шаардлагатай тоноглолоор тохижуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



<http://ammt.gov.mn/contact>





АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖААНЫ ЗӨВЛӨХ БЭЛТГЭХ СУРГАЛТ

“Монголын ажил мэргэжлийн мэргэшсэн зөвлөхүүдийн хэлбэр” ТББ

Аль ч насны хүнд боловсрол, сургалтын талаар мэдээлэл өгөх, ажил мэргэжлийн сонголт хийхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, чиглүүлэх хэлбэрээр мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ үзүүлэх нь АММТ-ийн гол зорилго юм. АММТ нь орчин цагийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан олон улсын түвшинд нийцүүлсэн, зөвлөгөө өгөх тусгайлсан өрөөтэй, тохилог анги, танхимтай мэдээллийн нэгдсэн сантай, цахим хэлбэр бүхий жишиг үйлчилгээг, мэргэжлийн өндөр төвшинд бэлтгэгдсэн, мэргэшсэн зөвлөхүүдээр дамжуулан хүргэх юм. Ажил, мэргэжлийн мэдээллийн төвд “Эрэлттэй ажил мэргэжлийн

талаар танилцах, хөдөлмөрийн аль ч салбарын мэдээллийг авах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, ганцаарчлан болон бүлгийн зөвлөгөө өгөх болон цахим хэлбэрээр чадамжийн сорил бөглөн өөрийн үр чадвар, авьяас билгээ танин, мэдэх боломжтой юм. Үүний зэрэгцээ хөдөлмөрийн салбарын мэргэжилтнүүд мэдээлэл, сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, хөдөлмөрийн яармаг, аялал болон хөдөлмөр эрхлэлтийн салбар дахь олон талт, жишиг үйл ажиллагааг тасралтгүй явуулна.


Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газарт Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх хүсэлт ирүүлэх ба хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд одоо ажиллаж буй ажилтнуудад мэргэшсэн зөвлөхийн гэрчилгээ олгуулах, шаардлагатай бол мэргэшсэн зөвлөхийн сургалтад хамруулах ажлыг 2017 оны 10 дугаар сараас эхлэн зохион байгуулж, Үнэлгээ мэдээллийн төвтэй хамтран ажиллаж байна.

АМЧБО зөвлөх бэлтгэх сургалт

Сургалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн Хөдөлмөрийн албаны дарга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн, ажил мэргэжлийн чиг баримжаа, ажилд зуучлал хариуцсан мэргэжилтэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд зориулан явуулдаг.

Оролцоо төсөл

Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний 2.6 дахь заалт болон 2021 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “ОРОЛЦОО” төслийн хүрээнд нийт 5000 гаруй залуусыг хувь хүний хөгжлийн цогц сургалтад 12 ээлжээр хамруулан хөдөлмөрт бэлтгэх юм.



“Оролцоо” төсөл нь залуучуудад эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бий болгож, ажилтай, орлоготой болгох зорилготой юм.

Төсөл нь залууст эрүүл, эртэч, амьдралын идэвхтэй хэв маяг, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх хэлбэрээр ажилтай, орлоготой болоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ хүрээнд өөрийгөө танин мэдэх, зөв дадал хэвшил, харилцаа хандлага, эх оронч үзэл санааг ойлгуулж, бие бялдын зөв хүмүүжил, гэр бүлийн эерэг харилцаа, соёл төлөвшүүлэхэд чиглэсэн багц сургалт явуулна.

Мөн ажил хөдөлмөрт бэлтгэх, ажлын ачаалал зэргийг даван туулах чадавхид сургах, хүн бүрийн онцлогт тохирсон ажил, мэргэжлийн зөвлөгөө өгч, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө гаргахад нь туслах юм.

Судалгааны ажлын дүгнэлт

АМЧБО зөвлөх үйлчилгээний талаарх төрийн тогтолцоо, эрх зүйн орчинг бүрдүүлэх нарийн тохируулга шаардлагатай нь энэхүү судалгааны явцад харагдаж байна. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг ажил мэргэжлийн түвшинд судлах нь бодлого боловсруулахад ихээхэн ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн зах зээлд бэлэн буй ажлын байрны шаардлагад сургалтын байгууллагаас нийлүүлэгдэж байгаа мэргэжилтэй шинэ ажилтнуудын үр чадвар нийцэж буй эсэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, хэлбэр, тэдний хэтийн төлөвлөгөө зэрэг асуудлыг тоон болон чанарын үзүүлэлтүүдээр дамжуулан судалж, түүнийг хэрэглэгчдэд хүргэж, бодлого боловсруулагчдад нөлөөлөх нь хамгийн чухал асуудал байдаг.

Ажил хайж байгаа иргэн ажлын байрны сонголт хийхдээ өсөн хөгжих боломж болон ажил мэргэжлийн ирээдүй, цалин, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааг илүү чухалчилж авч үздэг байна.

ЕБС-ийн сурагчид, тэдний эцэг эх рүү чиглэсэн АМЧБО зөвлөх үйлчилгээ төдийлөн хүртээмжтэй бүс байгаа нь анзаарагдсан. Мэргэжил сонголтын үйл явцад сурагч, эцэг эх анхаарал хандуулахгүй, мөн чухал ба чухал бүс эсэхийг ойлгохгүй байгаа нь дараагийн шатны сургуульд элсэх, мэргэжлээ сонгоход хүндрэл үүсэх магадлалтай байж болох юм.

ЕБС-ийн зорилтод бүлгийн суралцагчид нь МСҮТ, ПК, их дээд сургуулийн дамжин өнгөрөх нэг цэг тул тэдэнд үзүүлэх АМЧБО зөвлөх үйлчилгээний зорилтод арга хэмжээг сургалтын хөтөлбөрийн агуулга, үйл ажиллагаатай уялдуулах ба нэгдсэн үзэл баримтлалтай байж, хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна.

Гадаадын зарим хөгжингүй орнуудад сүүлийн үед мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаанд бие хүний хөгжлийн асуудлыг илүүтэй анхаардаг болж эхэлж байна.

Төсөл хөтөлбөрийн дэд зорилтод АМЧБО зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх асуудал багтсан байдаг тул цаашид энэ арга хэмжээг хэрэгжүүлэгч төсөл хөтөлбөрийг хариуцсан мэргэжилтэн, асуудлыг харьяалах бодлого боловсруулагч нарын уулзалт зөвлөгөөнийг хийх замаар үйл ажиллагааны давхацлыг арилгах, хамтын ажиллагааны уялдааг сайжруулах шаардлагатай байна.

АМЧБО зөвлөх үйлчилгээг хөтлөх мэргэшсэн зөвлөх, мэргэжилтэнг системтэйгээр бэлтгэх, тасралтгүй сургаж хөгжүүлж бэлтгэгдсэн мэргэжилтний ажлын байрны тогтвортой байдлыг хадгалах, хариуцлагын механизмыг удирдлагын түвшинд бий болгох нь нэн чухал юм.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний хамрах хүрээ, агуулга, зохион байгуулалт, санхүүжилтийн хэм хэмжээг тогтоосон эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах хэрэгцээ харагдаж байна.

Хүүхдэд мэргэжлийн ойлголтыг багаас нь системтэй өгөх нь хувь хүний болон хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн хөгжилд урт хугацааны өндөр үр өгөөжтэй болохыг өндөр хөгжилтэй орнуудын жишээ байгаа тул бага, дунд, дээд боловсролын салбарт энэ чиглэлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд бэлтгэсэн цахим хуудсыг зорилтот бүлэг, олон нийтэд сурталчлан хүргэх ажлыг эхлүүлж хэрэглээг нэмэгдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэн баяжуулах нь хэрэглэгчдийн эрэлтийг хангах алхам болно.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний агуулгыг мэргэжлийн сургалт, амьдрах ухаан, албан бус сургалтын агуулгатай уялдуулан шинэчлэн боловсруулж мөрдөж цахим талбаруудыг уялдуулан мэдээллийн нэгдсэн талбар бий болгох нь хэрэглэгчдэд дөхөм байх давуу талтай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ

1. Мэргэжлээ зөв сонгох нь, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв, УБ хот, 2013
2. Зөв сонголт-мэргэжил гарын авлага, Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Ерөнхий Газар, УБ хот, 2017
3. Мэргэжлээ сонгох нь, Д.Гомбо, 2013
4. Ажил мэргэжлийн зөвлөгөө, ММСС, МБС-ын төсөл, АМЧБО тухай гарын авлага, УБ хот, 2011
5. Өөртөө итгэх итгэл, амьдрах ухааны чадвар чиглүүлэгчийн багц гарын авлага, Модуль 1-8, УБ хот, 2016
6. Цаг төлөвлөлтийн арга зүй, Болорцэцэг
7. Ажил хэргийн гурвалжин, Хувь хүний хөгжил цуврал, Ц.Баатархүү, УБ хот, 2008
8. Төлөвлөгөө зохиох алхам, тухайн алхамд гүйцэтгэх гол ажлууд, Б.Урнаа, УБ хот, 2013
9. Соёлтой хүн, О.Амарбаясгалан, УБ хот
10. Хэл ярианы соёл, Ц.Бат-Эрдэнэ, УБ хот, 2017
11. Карьер гэж юу вэ? Б.Тунгалаг, УБ хот, 2016
12. Ажлын хөтөч, Ажил хайж буй иргэдийн ширээний ном, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар, УБ хот

Илтгэл

1. Үүрэг хариуцлагаа ухамсарла, илтгэл, Н.Багабанди, УБ хот, 2011
2. Өөртөө итгэлтэй харилцах чадвар илтгэл, Х.Санжаажамц, УБ хот, 2014
3. Үнэт зүйл илтгэл, С.Энх-Амгалан, УБ хот, 2014
4. The push and pull of TVET: can Career Guidance make a difference? 3rd UNESCO International TVET Conference, Shanghai, 13-16 May 2012, Ronald G. Sultana, University of Malta

Гадаад эх сурвалж

1. What is Personal Time Management, Jirard M.Blair, 2010
2. Decision making, Trudy Griffin, 2019
3. Career guidance: Handbook for policy makers, OECD, 2004
4. Career Guidance and Public Policy: Bridging the Gap, Paris. Sultana, R.G. (2004), Guidance Policies in the Knowledge Economy. Trends, Challenges and Responses, OECD (2004)
5. Public Policies for Career Development. Case Studies and Emerging Issues for Designing Career Information and Guidance Systems in Developing and Transition Economies, The World Bank, Watts, A.G. and D. H. Fretwell , 2004, Washington
6. Australian blue print for Career development services,

Онлайн эх сурвалж

1. www.academia.com
2. www.ukatumur.com
3. www.biznetwork.mn/content
4. www.hrmci.mn
5. www.timeplanning.net
6. www.monicabatsukh.com
7. www.umassd.edu/fycm/decision-making/process
8. www.facebook.com/HuwiHuniiHugijl/
9. <http://irgetas.wordpress.com/2013/03/31>карьер төлөвлөлтөө хэрхэн хийх вэ
10. <http://bayarchimeg-chulludai.blogspot.com/2011/02/n-ce.html>, Их дээд сургуулийн оюутнуудад мэргэжлийн ёс зүй төлөвшүүлдэг гадаадын зарим орнуудын туршлага
11. <http://www.unread.today>
12. <http://www.slideshare.net/azora14>
13. www.corporate.mn
14. <http://uuganaa93.blogspot.com>
15. www.businessphrases.net/hard-skills-list/
16. www.peak.mn/news/softskills-chuhaluu-hardskills-chuhaluu
17. <http://mlctraining.mn>
18. <https://www.facebook.com/pages/category/Magazine/Эрдэм-Мэдлэгийг-Бүтээцгээ-1447981735512259/>
19. <http://www.facebook.com/YouthBusinessMongolia>
20. <http://www.sanhuugiinbolovsrol.mn>
21. <http://bizguide.mn>
22. www.iiste.org
23. <http://cica.org.au/the> Career Industry Council of Australia
24. <https://www.education.gov.au/australian-blueprint-career-development> The Australian Blueprint for Career Development (ABCD)
25. <http://www.education.gov.au/job-guide>
26. <http://myfuture.edu.au/My Future Australia>
27. <https://www.education.gov.au/career-bullseye-posters>
28. <https://www.google.com/search?q=career+education+south+korea>
<https://www.google.com/search?q=ecd+curriculum+singapore>